

2022

Хэрэглэгчийн үнэлгээ-2022 он

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР
USER

“АЖИГЛАЛТ” НҮТББ |

СУДАЛГААНЫ БАГ

ЦЭРЭНЖИГМЭД НУГАРМАА Төслийн удирдагч, “Ажиглалт” НҮТББ-ын
Тэргүүн ЛХАГВА ЭНХБАЯР “Ажиглалт” НҮТББ-ын Гүйцэтгэх захирал
БАТ-ОЧИР АЛТАНЦЭЦЭГ Судлаач, “Ажиглалт” НҮТББ-ын УЗ-ийн гишүүн

БУДСҮРЭН ДАГИЙРАНЗ Судлаач, туслах
ажилтан БЯМБАДОРЖ БАТБАЯР

Судлаач, туслах

ажилтан

2022.12.06.

ГАРЧИГ

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

СУДАЛГААНЫ БЭЛТГЭЛ АЖИЛ, СУДАЛГААНЫ
АРГАЧЛАЛ СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

БАРИМТ БИЧГИЙН

СУДАЛГАА СУДАЛГААНЫ

ХАМРАХ ХҮРЭЭ

СУДАЛГААНЫ

ТҮҮВЭРЛЭЛТ

АСУУЛГЫН БҮТЭЦ, БОЛОВСРУУЛАЛТ

СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

- 1.1. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ТҮҮНИЙ БИЕЛЭЛТИЙН
ҮНЭЛГЭЭ
- 1.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ СЭТГЭЛ ХАНАМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- 1.3. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН ҮНЭЛГЭЭ

ХОЁР ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- 2.1. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ИЛ
ТОД БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖИЙН ҮНЭЛГЭЭ
- 2.2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ
- 2.3. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГА ИРГЭДИЙН

ҮНЭЛГЭЭ ДҮГНЭЛТ:

ЗӨВЛӨМ

Ж:

ХАВСРАЛ

Т

УДИРТГАЛ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хэрэглэгчийн үнэлгээг “Ажиглалт” НҮТББ байгууллага Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн.

Энэхүү Хэрэглэгчийн үнэлгээний зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд чиглэсэн бодлого, шийдвэр чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино. Тухайн зорилгын хүрээнд тус байгууллагын бодлого, үйл ажиллагаа иргэдэд хэрхэн хүрснийг үнэлэн, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг судлаж, иргэдээс авсан санал асуулгын дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэж байна.

“Ажиглалт” НҮТББ нь хэрэглэгчийн үнэлгээний ажлын удирдамжийг боловсруулахдаа байгууллагын онцлог, хамарч буй хүрээ, бодлогын хүртээмжтэй байдлыг анкетын санал асуулга, ярилцлагын арга, харьцуулалтын аргыг хэрэглэн үнэлэхийг зорьсон бөгөөд статистик болон тоон мэдээлэл цуглуулсан болно. Хүн амын дотор насанд хүрсэн иргэдийн 5 хувиар бодож Нийслэлийн 7 дүүрэг, нийслэлийн орон нутгийн 4 анги буюу 760 гаруй иргэдээс төрийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэсэн болно. Түүнчлэн 96 төрийн албан хаагч, хуульчдаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий байгууллагын үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэсэн. Мөн анкетын судалгааны зарим асуулгыг чанар\ярилцлагын\ын судалгаагаар баталгаажуулсан. Чанарын судалгааг иргэн, төрийн албан хаагч, судлаачдыг оролцуулан 8 хүнтэй ярилцлага хийсэн болно.

Судалгааны зорилго, зорилт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар түүний харьяа байгууллагуудын зүгээс иргэд олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг үнэлүүлэх, санал авах, үндсэн бодлого үйл ажиллагааг сайжруулахад судалгааны зорилго оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан болно. Үүнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх
2. 2022 онд иргэдэд чиглэсэн гол төсөл, хөтөлбөр болон нэвтрүүлгийн талаарх мэдээлэл, үнэлгээг тодорхойлох

3. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, албан хаагчдын харилцаа, ёс зүй, үйлчилгээний орчны талаарх иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх
4. Төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн суваг, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах саналыг тодорхойлох зорилтуудыг дэвшүүлсэн болно.

Судалгааны бэлтгэл ажил, судалгааны аргачлал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үйл ажиллагаа, түүний чанар хүртээмжийг судлаж, түүнд иргэдийн сэтгэл ханамж хэр байгааг тодорхойлохын тулд анкетын санал асуулгыг мэргэжлийн түвшинд бэлтгэж, дүгнэлээ. Өөрийн байгууллагын судлаачдын хүчийг ашиглахын зэрэгцээ мэргэжлийн судалгааны ажилтантай гэрээ байгуулан ажилласан.

Судалгааны аргачлал:

Тоон судалгаа: Анкетын судалгаа

Чанарын судалгаа: Анкет ярилцлага

Суурь судалгааны хүрээнд: Бичиг баримтын 2 төрлийн судалгааг хийж гүйцэтгэсэн.

Анкет

Нийслэлийн 7 дүүрэг, орон нутгаас судалгаанд оролцсон иргэд /Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа - А/, төрийн албан хаагчид болон харьяа байгууллагын ажилтан албан хаагчид, хуульчдаас /Төрийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа - Б/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хэрэгжиж буй хөтөлбөр, үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаа эсэх, харьяа байгууллагын үйлчилгээнд өгч буй үнэлгээ, тус байгууллагын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл, шалтгаан, хүчин зүйлийг шинжлэн судлахад чиглэгдсэн. Анкетын судалгааны асуумжид захиалагч талын санал зөвлөмжийг тусгасны зэрэгцээ арга зүйн хувьд харьцуулан судлах, боловсруулах боломжтой, цаашид авч хэрэгжүүлэх бодлого шийдвэрүүдэд тусгаж болохуйц асуултуудыг оруулсан болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэрэглэгчийн үнэлгээг гэрээ хийгдсэн хугацаанд амжилттай хийсэн болно.

Ганцаарчилсан ярилцлага

Судалгаанд хамруулахаар сонгосон экспертүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага чиг үүргээ хэрхэн гүйцэтгэж байгаа тал дээр үнэлэлт дүгнэлт авч анкетын судалгааг чанаржуулах, ганцаарчилсан ярилцлагаар тоон судалгаанаас төдийлөн гарах боломжгүй, тухайн салбартай холбоотой асуудлыг илрүүлэн гаргахыг зорьсон. Экспертүүдтэй хийх ярилцлагын үед оролцогчид асуудлыг олон талаас тодруулах, шалтгаан нөхцөлийг илүү гүнзгий тайлбарлах боломжтой байдаг. Ганцаарчилсан ярилцлагыг биечлэн болон утсаар холбогдон хийж, чанарын шинжилгээний мэдээлэл боловсруулах аргаар гүйцэтгэсэн болно.

Баримт бичгийн судалгаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг үнэлэхийн тулд холбогдох статистик мэдээлэл, үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт, одоо хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр болон үйлчилгээтэй холбоотой ирсэн гомдол, мэдээлэл, байгууллагын цахим хуудасны мэдээлэл болон холбогдох бусад баримт бичгүүдийг цуглуулан дүн шинжилгээ хийв.

Хүснэгт 1. Суурь болон ажиглалтын судалгаа

Д/д	Судалгааны багц	Судалгааны төрөл	Түүвэр дэх шалгуур
1.	Суурь судалгаа	Асуулга судалгаа	Сонгосон дүүргийн иргэд, төрийн албан хаагчид
		Анкет ярилцлага	Асуулгын асуултыг илүү нарийвчилсан байдлаар алба хаагчид болон экспертүүд, иргэнээс учир шалтгааныг тодруулсан нэмэлт тодруулга авсан
2.	Ажиглалтын судалгаа	Цахим хуудасны шинжилгээ	Цахим хуудсанд тодорхой шалгуураар үнэлгээ хийх


Хэрэглэгчийн итгэл үнэмшлийн үнэнч байдлыг хэмжих зорилгоор “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэдэд үзүүлсэн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдал өмнөх жилтэй харьцуулахад хэр их ахиц гарсан бэ?”, -10 оноо, огт санал болгохгүй-0 буюу 0-10 онооноос сонголт хийлгэсэн.

Хариултын онооноос шалтгаалан хэрэглэгчийг гурван түвшинд авч үзсэн. Үүнд:

1. Дэмжигч хэрэглэгч (9-10 оноо)
2. Эргэлзэгч хэрэглэгч (7-8 оноо)
3. Үл итгэгч (0-6 оноо)

Үр дүнг дэмжигч хэрэглэгч /9-10 оноо/-ийн хувиас үл итгэгч хэрэглэгч /0-6 оноо/-ийг хасаж хэрэглэгчийн өсөлт, үнэнч байдлыг тооцсон. Үнэнч байдлын утга сөрөг тэмдэгтэй гарч болно. Энэ нь сөрөг мэдээллийн итгэгдэх байдал, бусдад мэдээллийн тархах байдал илэрхийлсэн хувиар тарах магадлал байгааг харуулна.

Зураг 2. Хэрэглэгчийн түвшин (NPS)



Судалгааны хамрах хүрээ:

Түүврийн харьцааг 70:30 байхаар тооцсон бөгөөд судалгаанд оролцсон иргэдийн 68% нь УБ хотын иргэд, 32% нь төрийн албан хаагч байгаа тул түүврийн бүтэц хангагдсан гэж үзэж байна.

Хэрэглэгчийн үнэлгээний анкетын судалгаанд 389 иргэн хамрагдсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа байгууллагын төлөөлөл болон Дархан уул аймаг дахь 445 дугаар анги, Баривчлахт төв байр, 409, 421 дүгээр ангиуд, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хуульчдаас авах асуулгад 265 хүн оролцсон. Мөн экспертийн түвшинд судлаач 3 үүнээс PhD 2, төрийн албаны удирдах болон ахлах ажилтан, иргэд, нийт 8 хүнтэй ярилцлага хийх замаар чанарын судалгааг авсан болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын цахим хуудаст шинжилгээ хийж, иргэд мэдээлэл авах боломжоор хангагдсан эсэхийг судалж цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг гаргасан.

Судалгааны түүвэрлэлт

Судалгааны түүвэрлэлтийг хийхдээ эх олонлогийг хэвийн тархалттай гэж үзэн энгийн санамсаргүй түүврийн аргыг ашигласан. Түүврийн хэмжээг тогтоохдоо дараах томъёог ашиглав.

$$n = \frac{t^2 * w * (1 - w) * N}{N * \Delta_p^2 + t^2 * w * (1 - w)}$$

Түүврийн хэмжээ 95%-ийн итгэх магадлалтай, +/- 5%-ийн алдааны хязгаартай байхаар тооцож, оновчтой түүврийг 389 хүн гэж тогтоов. Төрийн албан хаагч, хуульчдийн хувьд түүврийг 96 хүн гэж тооцов.

Хүснэгт 2. Түүврийн бүтэц

Иргэд				Алба хаагчид		
Аймаг, нийслэл	Дүүрэг	Тоо	Хувь	Байгууллага	Тоо	Хувь
УБхот	БГД	43	11%	Нийслэлийн ШШГГ	21	22%
УБ хот	БЗД	45	12%	409 дүгээр анги	11	12%
УБ хот	СБД	43	11%	Баривчлах төв	10	11%
УБ хот	СХД	47	12%	Баривчлах байр	6	6%
УБ хот	ХУД	39	10%	445 дугаар анги	3	3%
УБхот	ЧД	42	11%	421 дүгээр анги	7	7%
ХЗДХЯ		26	7%	Бусад	37	39%
Дархан-Уул аймаг		44	11%	Нийт	95	100%
ХЭҮК		50	13%			
	Нийт	379	100%			

Алба хаагчдын судалгаанд 95 хүн хамрагдсан, 48% нь эмэгтэй, 52 хувь нь эрэгтэй, насны хувьд 41% нь 36-45 настай, 29% нь 46-аас дээш настай, 27% нь 26-35 настай, 2% нь 18-25 настай албан хаагчид оролцжээ. Боловсролын хувьд 52% нь магистр 42% нь бакалавр, 5% нь доктор, 1% нь бүрэн дунд боловсролтой байна.

Хүснэгт 3. Судалгаанд оролцсон төрийн албан хаагчийн хүн ам зүйн мэдээлэл

Асуулт	Хариулт	Тоо	Хувь
Насны бүлэг	18-25 нас	2	2%
	26-35 нас	26	27%
	36-45нас	39	41%
	46-аас дээш	28	29%
	Нийт	95	100%
Хүйс	Эмэгтэй	46	48%
	Эрэгтэй	49	52%
	Нийт	95	100%
Боловсрол	Бүрэн дунд /10/11/12 анги/	1	1%
	Дээд /Бакалавр/	40	42%
	Дээд /Доктор/	5	5%
	Дээд /Магистр/	49	52%

Иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд 389 хүн хамрагдсанаас 10 анкет хүчингүй болж 379 иргэн хамрагдсан. Үүний 61% нь эмэгтэй, 39% нь эрэгтэй, насны

25 настай, 25% нь 26-35 настай, 36% нь 36-45 настай, үлдсэн 29% нь 46-аас дээш настай иргэд байна. Боловсролын хувьд 78% нь дээд, 13% нь бүрэн дунд, 4% нь Техник болон мэргэжлийн дунд (МСҮТ), 3% нь Суурь /8, 9 анги/ боловсролтой, үлдсэн 2% нь боловсролгүй/бага гэсэн ангилалд хамаарагдаж байна.

Ажил эрхлэлтийн байдлыг харвал 90% нь ажил хөдөлмөр хийдэг, үүний 40% нь төрийн байгууллагад ажиллаж байна. Ажилгүй иргэд 8%-ийг эзэлж байна.

Хүснэгт 4. Судалгаанд оролцсон иргэдийн хүн ам зүйн мэдээлэл

Асуулт	Хариулт	Тоо	Хувь
Насны бүлэг	18-25 нас	40	11%
	26-35 нас	93	25%
	36-45 нас	136	36%
	46-с дээш	110	29%
	Нийт	379	100%
Хүйс	Эмэгтэй	230	61%
	Эрэгтэй	149	39%
	Нийт	379	100%
Боловсрол	Боловсролгүй /бага	6	2%
	Суурь /8, 9 анги/	13	3%
	Бүрэн дунд	65	17%
	Техник болон мэргэжлийн дунд (МСҮТ)	16	4%
	Дээд	295	78%
	Нийт	379	100%
Ажил эрхлэлт	Ажилгүй	31	8%
	Төрийн байгууллага	151	40%
	ТББ/Олон улсын байгууллага	20	5%
	Хувийн хэвшил, компани	72	19%
	Хувиараа бизнес эрхэлдэг	42	11%
	Малчин, тариаланч	4	1%
	Бусад	53	14%
	Хариулаагүй	6	2%
	Нийт	379	100%

Асуулгын бүтэц, боловсруулалт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2022 оны Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны асуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15- ны өдрийн 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг үндэслэл болгон боловсруулсан. Анкетын судалгаа – А нийт зургаан бүлэг 72 асуулттай. Судалгааг мэдээллийг IBM SPSS 23.0 программ ашиглан боловсруулав.

Хүснэгт 5. Анкетын асуулгын бүтэц /Анкет -А/

Бүлэг	Асуултын тоо	Агуулга
Нэгдүгээр бүлэг	16 асуулт	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамжийн үнэлгээ, иргэдийн оролцоо, мэргэжил арга зүйн туслалцаа хэр үзүүлдэг, техник технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа хэр ашигладаг, албан хаагчид авлигаас ангид шударга ажиллаж байгаа байдал, үйл ажиллагааны шуурхай байдал, албан хаагчдын харилцаа хандлагын үнэлгээ, санал, гомдолд хариу өгөх байдал зэрэгт өгөх үнэлгээ
Хоёрдугаар бүлэг	8 асуулт	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын харьяа байгууллагуудад өгөх сэтгэл ханамжийн үнэлгээ, бодлого шийдвэрүүд хэр ил тод нээлттэй байгаа, эдгээр байгууллагуудын талаарх мэдээлэл, үйл ажиллагааны үнэлгээ, шуурхай байдал, ажилтнуудын харилцаа хандлага, санал гомдолд хариу өгөх байдал, залгамж холбоо зэрэг асуудлын үнэлгээ
Гуравдугаар бүлэг	6 байгууллагы н талаарх 6 асуулт	Үйл ажиллагааны хэрэгжилт үр дүн, ил тод нээлттэй байдал, авлигаас ангид шударга байдал, түргэн шуурхай байдал, ажилтан албан хаагчдын харилцаа, хандлага, гадна, дотно тохижилт, үйлчилгээний ая тухтай орчинг бүрдүүлсэн байдлын үнэлгээ
Дөрөвдүгээр бүлэг	22 асуулт	Хууль, дүрэм журам хүн бүрт тэгш үйлчилж байгаа эсэх, хуулийн төсөлд хэр оролцдог, иргэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд хэр хяналт тавьж байгаа зэрэг асуудлуудыг үнэлэх
Тавдугаар бүлэг	14 асуулт	Үйлчилгээний чанар хүртээмж, албан хаагчдын харилцааны соёл, ёс зүй болон үйлчлүүлсэн байгууллагын орчны үнэлгээ, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлын өмнөх жилтэй харьцуулсан ахицын үнэлгээ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг сайжруулахын тулд хүсч буй ажил болон өмнөх жилээс үр дүнтэй ажлыг үнэлэх
Зургаадугаар бүлэг	5 асуулт	Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл

Анкетын судалгаа – Б нийт дөрвөн бүлэг 55 асуулттай. Судалгааг мэдээллийг IBM SPSS

23.0 программ ашиглан боловсруулав.

Хүснэгт 6. Анкетын асуулгын бүтэц /Анкет -Б/

Бүлэг	Асуултын тоо	Агуулга
<i>Нэгдүгээр бүлэг</i>	<i>6 асуулт</i>	<i>Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл</i>
<i>Хоёрдугаар бүлэг</i>	<i>16 асуулт</i>	<i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд</i>

		<i>өгөх үнэлгээ, үйл ажиллагааны нээлттэй байдал, техник, технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа хэр хэрэглэдэг, авлигаас ангид, шударга байдлын үнэлгээ, үйл ажиллагааны шуурхай байдал, ажилтан албан хаагчдын харилцаа, хандлага, гомдолд хариу өгөх байдлын үнэлгээ</i>
Гуравдугаар бүлэг	<i>7 байгууллагын 6 асуулт</i>	<i>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харъяа байгууллагуудад өгөх үнэлгээ, үйл ажиллагааны хэрэгжилтүр дүн, ил тод нээлттэй байдал, авлигаас ангид шударга байдал, түргэн шуурхай байдал, ажилтан албан хаагчдын харилцаа хандлага, гадна дотно тохижилт үйлчилгээний ая тухтай байдлыг бүрдүүлсэн байдал зэрэгт үнэлгээ хийх</i>
Дөрөвдүгээр бүлэг	<i>27 асуулт</i>	<i>Иргэдийн оролцоо, хууль, дүрэм журам хүн бүрт тэгш үйлчилж байгаа эсэх, эрх зүйн тусламж шаардлагатай үед хэнд хаана хандахаа хэр сайн мэдэх зэрэг асуудлуудыг үнэлэх</i>

Судалгааны ажлын зохион байгуулалт

Судалгааны ажил нь гэрээний дагуу мэдээлэл, цахим сүлжээний сүүлийн үеийн дэвшилтэд технологийг ашиглах замаар цахим болон бусад хэлбэрээр амжилттай хийж гүйцэтгэсэн. Тоон судалгааны мэдээллийг 2022 оны 10 дугаар сарын 12-оос асуултыг боловсруулж эхлэн 11 сарын 25-аас 12 дугаар сарын 8-ны өдрийг хүртлэх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Чанарын судалгааны мэдээллийг 2022 оны 11 сарын 10-наас 12 сарын 04-ны өдрүүдэд ярилцлага болон цахим сүлжээг ашиглан ярилцаж цуглуулсан.

----- о О о -----

НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ҮЙЛ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 2022 онд 4 зорилтын хүрээнд 55 буюу /арга хэмжээ тус бүрээр тооцвол 93 арга хэмжээ/ арга хэмжээг төлөвлөн ажилласан байна.

Жич: Байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт тус бүрийг ЗГХЭГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлгээ өгч тооцон дүгнэлээ.

№	Зорилт	Зүйл, заалтын н тоо	Хэрэгжилтэд өгсөн үнэлгээ				Дундаж	
			30	70	90	100	Хувь	оноо
1.	Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	22	1	-	10	11	92.2	4.6
2.	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт	38	2	4	9	23	90.7	4.5
3.	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт	27	1	3	6	17	91.8	4.5
4.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт	6	-	1	2	3	91.6	4.5
Нийт		93	4	8	27	5	91.5	4.5

Тус байгууллагын 2022 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн нийт үнэлгээ 91,5 буюу 4,5 гэсэн оноотой байгаа нь тухайн байгууллагын 2022 онд төлөвлөсөн ажлууд хир үр дүнтэй хэрэгжсэн байгааг харуулж байна.

Томоохон 4 зорилтын хүрээнд хийгдсэн зарим ажлуудаас дурдвал:

1.ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах чиглэлээр:

Харьяа хорих анги, байгууллагын үйл ажиллагааг шалган зааварчлах чиглэлээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргуулахгүй байх талаар удирдлага, зохион байгуулалтыг ханган ажилласан байна.

Харуул хамгаалалтын хэлтсээс хорих анги, байгууллагуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, холбогдох бусад хууль, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон яллагдагч, хоригдолд тавих

хяналт, харуул хамгаалалтыг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хуульд заасан ахуй нөхцлөөр хангах, тэдний дундаас гарч болзошгүй орголт, гэмт хэрэг, зөрчил, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт хорих анги, байгууллагад үүрэг, чиглэл, зөвлөмжийг хүргүүлж, хяналт тавин хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

ШШГЕГ-ын Тэргүүн Дэд дарга бөгөөд Хорих ял эдлүүлэх албаны даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 09 дүгээр сард Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь ШШГХ-

423 дугаар анги, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь ШШГХ-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид Булган аймгийн ШШГГ-ын үйл ажиллагааг шалган зааварчилж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан байна.

Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтэс нь 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 401, 405, 407, 409, 421, 425, 429, 441 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги, Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага, Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги нийт 10 хорих анги, байгууллагын нийгэм, сэтгэл зүйн нэгжийн үйл ажиллагааг шалган зааварчлан “Хоригдогсдын нэгдсэн цахим тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангах, “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай нийт 10 үүрэг, зөвлөмжийг тус тус хүргүүлж ажилласан байна.

Улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтөлж, хоригдогсдын бүртгэл хяналтын системийн баяжилтад хяналт тавих хүрээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлын хөдөлгөөн нэг бүрийг бүртгэлд авч, нэгдсэн мэдээ, судалгааг сар бүр Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газарт тогтмол хүргүүлсэн байна.

Хоригдогчдын тоо, нэрсийг хорих анги, салбар, нэгж бүрээр хоригдогсдын цахим бүртгэлийн системтэй тулгаж, нийт 880 хүнийг шалгаж, зөрүүтэй, дутуу оруулсан мэдээллийг тоо бүртгэлийн байцаагч, туслах нарт мэдэгдэн, зөрчлийг арилгах талаар үүрэг өгч, “Хоригдогсдын нэгдсэн цахим тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”- ыг баримтлан ажилласан байна.

Хорих ангид ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд:

Суллагдахын өмнөх үеийн нийгэмшүүлэх ажлыг мэргэжлийн боловсрол олгох сургалттай уялдуулан 2022 оны 03 дугаар улирлын байдлаар хорих анги, байгууллагуудыг харьяа бүртгэлийн байгууллагатай хамтран бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулж нийт **149** хоригдлыг хамруулсан байна.

2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар бичиг үсэг үл мэдэгч **388** хоригдол ял эдэлж байна. Хорих анги, байгууллагын нийгмийн ажилтнууд нь бие даан **160** хоригдлыг бичиг үсэг эзэмшүүлэх сургалтад хамруулж, **94** хоригдлыг уншиж, бичиж сургасан байна.

Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага, 437 дугаар нээлттэй хорих ангиуд нь **33** хоригдлыг ерөнхий боловсролын болон суурь боловсролын сургалтад хамруулсан байна.

2022 оны 10 дугаар сарын байдлаар ШШГБ-ын хэмжээнд мэргэжилгүй 1858 хоригдол ял эдэлж байна.

Үүнээс: Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 407, 413, 415, 417, 421, 425, 427, 429, 441, дүгээр нээлттэй, хаалттай хорих ангиудад барилгын засал чимэглэлчин, цахилгаанчин, гагнуурчин, өрөг угсрагч, тогооч, мужаан, сантехникч, бетон арматурчин мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, амжилттай үнэлэгдсэн **328** хоригдолд “Мэргэжлийн үнэмлэх”; 407, 409, 413, 415, 427, 429, 433 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, Үйлдвэр аж ахуй барилгын хэлтэс, СМДӨАХХГ барилгын сантехникч, засал чимэглэлчин, цахилгаанчин, гагнуурчин, бетон арматурчин, өрөг угсрагч, мужаан, оёмол бүтээгдэхүүний оёдолчин, арьсаар гар урлалын зүйл урлаач мэргэжлээр мэргэжлийн сургалтыг зохион байгуулж, амжилттай

үнэлэгдсэн **311** хоригдолд “Чадамжийн гэрчилгээ”-г тус тус олгосон байна.

2022-2023 оны хичээлийн шинэ жилийн элсэлтийг зохион байгуулж, 407, 409, 413, 421, 427, 429, 433, 441 дүгээр нээлттэй, хаалттай хорих ангид барилгын сантехникч, засал чимэглэлчин, цахилгаанчин, гагнуурчин, бетон арматурчин, өрөг угсрагч, мужаан, тогооч мэргэжлээр нийт **232** хоригдолд мэргэжлийн боловсрол олгох сургалтыг, СМДӨАХХГ оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлээр **19** эмчлүүлэгчийг мэргэжлийн сургалтад тус тус хамруулсан байна.

Мөн Баян-Өлгий аймаг дахь ШШГГ нь Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран аж ахуй үйлчилгээнд ял эдэлж байгаа 2 хоригдлыг барилгын засал чимэглэлчин мэргэжлээр мэргэжлийн сургалтад, 437 дугаар нээлттэй хорих анги нь “Лана Луна” ХХК-ны дэргэдэх мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын төвтэй хамтран 22 хоригдлыг хүнд машин механизмын оператор, 3 хоригдлыг гагнуурчин мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтад хамруулж, мэргэжлийн үнэмлэх олгосон байна.

Архангай аймаг дахь ШШГГ нь Архангай аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран 2 хоригдлыг цахилгаанчин, тогооч, мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох, Дорноговь аймаг дахь ШШГГ нь Дорноговь аймгийн Политехникийн коллежтой хамтран 2 хоригдлыг ойжуулалтын чиглэлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтад тус тус хамруулсан байна.

Суллагдахын өмнөх сургалтад давхардсан тоогоор 1,221 хоригдлыг хамруулсан бөгөөд 415 дугаар нээлттэй, хаалттай хорих анги 4, 417 дугаар нээлттэй хорих анги 4, 421 дүгээр нээлттэй хорих анги 15, 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги-1, 425 дугаар нээлттэй хорих анги 9, 435 дугаар хаалттай хорих анги-3 нийт 36 иргэнийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажлын байранд зуучлан нийгэмд бие даан амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан байна.

2022 оны 11 дүгээр сарын байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 158 хөгжлийн бэрхшээлтэй хоригдол ял эдэлж байна.

Үүнээс ажлын байраар хангагдсан 83, групп сунгуулсан 17, ортопед, протез олгосон 3 хоригдол байна. 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид тэргэнцэр-2, суга таяг-1, нийт-3 протез, ортопед олгосон.

Өндөр настай хоригдлуудын хууль эрх зүй, нийгмийн баталгааг хангах тэдний урьд тогтоолгосон тэтгэвэр, тэтгэмжийг үргэлжлүүлэн авах хуульд заасан болзол шаардлагыг хангасан тохиолдолд хуулиар тогтоосон тэтгэвэр, тэтгэмжийг олгуулах ажлыг зохион байгуулж, нийт **87** хоригдолд урьд авч байсан өндөр насны тэтгэвэр, **25** хоригдолд “Насны хишиг”-ийг олгосон байна.

Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах хүрээнд:

2022 оны 11 дүгээр сарын байдлаар байдлаар 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг-5, 429 дүгээр хаалттай хорих анги-Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг-5, Цагдан хорих 461 дүгээр ангийн эмнэлэг-1, шаардлагатай нийт 11 тоног төхөөрөмжийг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Иргэний, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хуульд нийцүүлэх, илэрсэн зөрчлийг зөвтгөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийг нэмэгдүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах.- Тайлант хугацаанд нийт

бичгийн 2.2 их наяд төгрөгийг биелүүлэхээс 11688 гүйцэтгэх баримт бичгийн 219.7 тэрбум төгрөгийг биелүүлж, 20012 гүйцэтгэх баримт бичгийн 2.0 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийн улсын дундаж үзүүлэлт 36.8 хувь, мөнгөн дүн 9.9 хувьтай ажилласан ба өмнөх оны мөн үеэс гүйцэтгэх баримт бичгийн статистик үзүүлэлт 4.6, мөнгөн дүн 1.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүүхдийн тэтгэлгийн биелүүлбэл зохих 12345 гүйцэтгэх баримт бичгийн 42.1 тэрбум төгрөгөөс 651 гүйцэтгэх баримт бичгийн 10.1 тэрбум төгрөгийг бодитой биелүүлснээс 7.2 тэрбум төгрөгийг хэсэгчлэн төлүүлжээ. Гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 5.3 хувийн үзүүлэлттэй, 11694 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна.

Төлбөрийн данс дахь мөнгөн хөрөнгийг эцэслэн шийдвэрлэх, төлбөр авагчид төлбөрийн мөнгийг даруй олгох, данс дахь орлогыг эцэслэн шийдвэрлэх тухай Ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврыг нэгжүүдэд хүргүүлж, аргачлалаар хангаж, хаяг тодорхойгүй төлбөр авагчид олгох, нийтэд зарласан мөнгийг хуульд заасны дагуу шийдвэрлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан байна.

Гэмт хэргийн хохирол, төлбөрийг барагдуулах, төрөөс нөхөн төлбөр олгох, баримт бичгийн бүрдүүлбэр хангах, санал гаргах үндэслэлийн талаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 74 алба хаагчдад цахим хэлбэрээр аргачлалаар хангах арга хэмжээ авсан байна.

ШШГЕГ-ын даргын 2022 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн Б/690 дүгээр тушаалаар бүс хариуцсан ахлах мэргэжилтнүүдийг хооронд нь сэлгэн ажиллуулах ажлыг зохион байгуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийг үндэслэн 8838 гүйцэтгэх баримт бичигт холбогдох 2.1 их наяд төгрөгийн төлбөртэй 7908 төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж, 1874 төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг сэргээж Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газартай харилцан мэдээлэл солилцон ажилласан байна.

Гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар 4 иргэнд

29.755.320 төгрөгийг олгохоор шийдвэрлүүлж, төлбөрийн мөнгийг шилжүүлсэн байна,

Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, уг хуульд нийцүүлэн баталсан “Гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-ын дагуу ажлын хэсгийн 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн хурлаар 49 иргэнд 375.093.132 төгрөг олгуулахаар хэлэлцэж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад албан бичгээр хүргүүлсэн байна.

Төрөөс олгосон нөхөн төлбөрийг эргэн төвлөрүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар нийт 2.4 тэрбум төгрөг биелүүлэхээс нийт 894.9 сая төгрөгийг барагдуулсан, үүнээс 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 135.3 сая төгрөгийг гэмт хэргийн хохирлын дансанд төвлөрүүлэн ажилласан байна.

Төвлөрүүлсэн мөнгийг төлбөр авагчдад хуваарилах ажлыг зохион байгуулах хүрээнд татан буугдсан 15 хадгаламж зээлийн хоршоонд холбогдох 31.002.039 төгрөг, эрүүгийн хэрэгт битүүмжлэгдсэн 949.576.725 төгрөг төлбөрийн дансанд байгаа ба

ажлын хэсгийн шийдвэрээр төлбөр авагчид мөнгөн хөрөнгө хуваарилах эх үүсвэр бүрдээгүй тул холбогдох арга хэмжээг 2022 оны 3 дугаар улиралд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Харин үнэлгээ тогтоох боломжгүй, шинжээчийн дүгнэлт бүхий хөдлөх эд хөрөнгийг Шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төвлөрүүлсэн 76.5 сая төгрөгийн нэр бүхий 56 хохирогчдод ажлын хэсгийн хурлын шийдвэрийг үндэслэн олгосон, мөн ажлын хэсгийн 2021 оны хурлаас үнэлгээ тогтоох боломжгүй хөдлөх эд хөрөнгийг хохирогчдод танилцуулах чиглэл өгч, уг арга хэмжээний хүрээнд 33.2 сая төгрөгийн үнэлгээ бүхий хөдлөх эд хөрөнгийг 2 төлбөр авагчаас үлдэгдэл төлбөрөөс хасч тооцуулж, хохирлын мөнгийг бүрэн шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан байна.

Уг иргэдийн хохирлыг шийдвэрлэх мөнгөн хөрөнгө төвлөрүүлсэн даруйд ажлын хэсгээс зохих саналыг хэлэлцэн шийдвэрлэхээр ажилласан байна.

Өнөөдрийн байдлаар татан буугдсан 26 хадгаламж зээлийн хоршоодын төлбөрт хүлээн авсан хөрөнгөөс 13 хадгаламж зээлийн хоршоонд холбогдох 31.7 сая төгрөгийн үнэлгээ бүхий 29735 ширхэг хөдлөх эд хөрөнгө, 4 хадгаламж зээлийн хоршоонд холбогдох 448.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий 6 ширхэг үл хөдлөх эд хөрөнгө тус тус худалдан борлогдоогүй, шийдвэрлэгдээгүй байна.

Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч үүрэг, чиглэл хүргүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих.-- Тайлант хугацаанд аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс харьяаллын дагуу шилжүүлэхээр ирүүлсэн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн 106 ялтанд холбогдох хяналтын хувийн хэргийг хянаж, шилжүүлсэн байна.

Орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс хорихоос өөр төрлийн ял эдэлж дууссан 132 ялтанд холбогдох эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон тогтоолын хувийг ирүүлснийг бүртгэн, цахим бүртгэлтэй тулгалт хийж, холбогдох судалгааны хамт Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Ls.info@polise.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. Мөн хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн эсэх талаар 169 этгээдийн лавлагааны хариуг гаргаж, харьяа дүүргүүдийн Цагдаагийн хэлтэс, тасгуудад албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 9233 ялтнаас 4572 ялтны ялыг бүрэн эдлүүлж, 4661 ялтан бүртгэл хяналтад байна.

Тайлант хугацаанд торгох ялаар шийтгүүлсэн 23, нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 86, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн 257, нийт 366 ялтны ялыг хорих ялаар сольж шийдвэрлэсэн.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 154 дүгээр зүйлд заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн 37 /торгох 5, нийтэд тустай ажил хийлгэх 14, зорчих эрхийг хязгаарлах 18/ ялтнаас 47 /торгох 15, нийтэд тустай ажил хийлгэх 12, зорчих эрхийг хязгаарлах 20/ ялтанд холбогдох эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээсэн байна.

Тайлант хугацаанд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр нэгдсэн 9, чиглэсэн 2, нийт 11 үүрэг, чиглэл хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааг шалган зааварчлах, илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байхад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 98, Налайх, Багахангай дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 82, Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 63, нийт 243 хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтанд холбогдох хяналтын хувийн

хэргийг шалган, зааварчлах ажлыг зохион байгуулж,

хариуцсан ахлах болон шийдвэр гүйцэтгэгч, техник хяналтын ажилнуудад ажлын байран дээрх сургалтыг явуулсан байна.

Албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авах чиглэлээр:

Тайлант хугацаанд аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс харьяаллын дагуу шилжүүлэхээр ирүүлсэн албадлагын арга хэмжээ авагдсан 89 этгээдэд холбогдох хяналтын хувийн хэргийг хянаж, шилжүүлсэн байна.

Орон нутаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсээс албадлагын арга хэмжээ авагдсан хяналтын хугацаа дууссан 63 этгээдэд холбогдох эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгосон тогтоолын хувийг ирүүлснийг бүртгэн, цахим бүртгэлтэй тулгалт хийж холбогдох судалгааны хамт Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Ls.info@polise.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. Мөн албадлагын арга хэмжээ авагдсан эсэх талаар 31 этгээдийн лавлагааны хариуг гаргаж, харьяа дүүргүүдийн Цагдаагийн хэлтэс, тасгуудад албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

Улсын хэмжээнд 4441 хүн, 3 хуулийн этгээдэд хяналт тавьж, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлж, хяналтын хугацаа дууссан 1300, харьяаллын дагуу шилжүүлсэн 84, хугацаанаас өмнө ялаас чөлөөлсөн 3, шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулсан 8, дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн 27, нас барсан 13, хяналтын хугацаа нь өршөөн хэрэгсэхгүй болсон 42, нийт 1477 этгээд хасагдсан байна. Одоогийн байдлаар тэнсэж, үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан 1158, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан 64, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоосон 974, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 119, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авагдсан 614, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 36, нийт 2965 хүн, эрх хасах албадлагын арга хэмжээ авагдсан 2 хуулийн этгээд тус тус хяналтад байна.

Улсын хэмжээнд хяналтаас зайлсхийсэн тогтоолын биелэлтийг хойшлуулсан 8 этгээдийг эрэн сурвалжилснаас 6 этгээдийг олж тогтоон, хяналтад авсан бөгөөд 2 этгээд /Нийслэл/-ийг эрэн сурвалжилж байна.

2022 оны 3 дугаар улирлын байдлаар албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр нэгдсэн 7 үүрэг, чиглэлийг хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласан байна.

Албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааг шалган зааварчилж, илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргуулахгүй байхад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх-Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний 61, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээний 74, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний 49, нийт 184 хяналтын хувийн хэргийг шалган зааварчилж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үүргийг хүргүүлэн ажилласан байна.

Мөн Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 69, Налайх, Багахангай дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 32, Багануур дүүрэг дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн 19, нийт 120 албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд

хэргийг шалган, зааварчлах ажлыг зохион байгуулж, хариуцсан ахлах болон шийдвэр гүйцэтгэгч, техник хяналтын ажилнуудад ажлын байран дээрх сургалтыг явуулсан байна.

Зөрчлийн гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжлийн удирдлагаар ханган, зохион байгуулалтын арга хэмжээг авах чиглэлээр:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/38 дугаар тушаалаар зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны харьяаллыг Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд тогтоосон 2020 оны А/36 дугаар тушаалыг хүчингүй болгосноор зөрчлийн гүйцэтгэх баримт бичгүүдийг Шийдвэр гүйцэтгэх албаны харьяалалд шилжүүлсэн байна.

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих чиглэлээр:

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих ажлын хүрээнд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар дараах үүргүүдийг хүргүүлсэн байна. Үүнд:

2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 4/103 дугаар албан бичгээр дотоодын халдвар хамгааллыг чангатган, урьдчилан сэргийлэх;

2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 10/352 дугаар албан бичгээр эмч, эмнэлгийн мэргэжилтний сул орон тоог нөхөх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, албадан эмчлүүлэгчдэд сургалт зохион байгуулах, нийгмийн ажил болон сэтгэл зүйчийн ажлын зааварт нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр ажил зохион байгуулах;

2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 04/935 дугаар албан бичгээр гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зэрэг үүргүүдийг хүргүүлсэн байна.

Мөн “Албадан эмчлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт”-ын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын эцсийн хэлэлцүүлгийг Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын удирдлага, алба хаагчдыг оролцуулан зохион байгуулж, төслийн эцсийн найруулгыг Эрүүл мэндийн яаманд уламжлан Стандартчиллын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулахаар шийдвэрлэсэн байна.

Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт 2021 оны жилийн эцсийн үлдэгдэл 126 хүн дээр тайлант хугацаанд шинээр 233 хүн нэмэгдэж, эмчилгээний үр дүнгээр 211 хүн чөлөөлөгдөж, өвчний учир 14, албадан эмчлэх тухай анхан шатны шүүхийн шийдвэр хэрэгсэхгүй болсон 2, шүүх, цагдаагийн байгууллагын дуудлагаар явсан 1 хүн тус тус хасагдсан ба 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 131 хүн албадан эмчлүүлж байна.

Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь архины хамааралтай хүнийг “Архины хамаарлын шалтгаант сэтгэц зан үйлийн эмгэгийн оношлогоо, эмчилгээ F10” Монгол Улсын стандарт /MNS5396-1:2018/-д заасны дагуу бие махбодийг хоргүйжүүлэх, хордлого тайлах, эрдэс бодисын

солилцоог тэнцвэржүүлэх, витамин эмчилгээ, тархины эд, эсийн солилцоо, цусан хангамж сайжруулах, солиорол, сэтгэл гутралын

эсрэг, шинж тэмдгийн, архинд дуршил бууруулах, архинд харшил үүсгэх өвөрмөц эмчилгээ, сэтгэл заслын эмчилгээнд тус тус хамруулсан байна.

2022 оны 3 дугаар улирлын байдлаар дараах сургалтуудыг зохион байгуулж, нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын эмнэлгийн дотоод журмаар 135, Архины хэрэглээний түвшин тодорхойлох нь сэдвээр 36, Архины хор хөнөөл сэдвээр 15, Архидалтын асуудал сэдвээр 3 удаа 40, Би яагаад энд ирэв сэдвээр 12, Архидалт ба гэр бүл сэдвээр 27, Дахилтаас сэргийлэх нь сэдвээр 2 удаа 33, Өөрийгөө хайрлан хамгаалах нь сэдвээр 30, Бататгах эмчилгээнд хамрагдах нь сэдвээр 2 удаа 24 эмчлүүлэгчид тус тус бүлгийн сургалт;

- “Дээд Бодь” хийдийн бясалгалын багш Ц.Бат-Итгэл, иогийн багш С.Баасанжав нараар 122 эмчлүүлэгчид “Смрти уластана” буюу санамсар мэдрэмжинд суурилсан бясалгал, иогийн хавсарсан сургалтыг тус тус зохион байгуулж ажилласан.

Мөн Нийслэлийн Багахангай дүүргийн Соёлын ордны болон Төв аймгийн Баян сумын номын сантай хамтран ажиллах гэрээ байгуулж, 855 (давхардсан тоогоор) эмчлүүлэгчид ном олгож уншуулсан бөгөөд Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвтэй хамтран 44 эмчлүүлэгчийг “Барилгын мужаан”, “Барилгын засал чимэглэлчин” мэргэжил олгох сургалтанд хамруулсан байна.

2. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ШШГБ-ын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт болон хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг 3 дугаар улирлын байдлаар нэгтгэн Хяналт шинжилгээ, үнэлгээний ажил хийгдэж байна.

Байгууллагын хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааг шат дараатай эрчимжүүлэх чиглэлээр:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/126 дугаар тушаалаар “ШШГБ-ын Жендэрийн асуудал хариуцсан дэд зөвлөл”-ийг шинэчлэн баталсан байна.

Тус зөвлөлийн 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан анги, байгууллагад албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг хагас, бүтэн жилээр ирүүлэх үүрэг өгсөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа 55 анги, байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам болон Жендэрийн үндэсний хорооноос хамтран зохион байгуулж буй “Харилцан хүндэтгэе”, “Хамтдаа үлгэрлэе” аяны хүрээнд постер, шторк бэлтгэн олон нийтэд хүргэхэд тус постерыг нийт 150 удаа хуваалцаж, 700 удаа хандалт хийсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагуудын хөдөлмөрийн дотоод журамд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн 11.4.1 дэх заалт/Ажлын байрны бэлгийн дарамт/ туссан эсэхэд хийсэн дүн шинжилгээг танилцуулах хэлэлцүүлэгт нийт **84** удирдах албан тушаалтанг хамруулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын гэр бүлийн гишүүдээс Монгол цэргийн нэгдсэн холбооны дэргэдэх “Бид мартаагүй” эмэгтэйчүүдийн клубээс Худалдаа хөгжлийн дээд сургуулийн дэргэдэх “Мэргэжил сургалт-үйлдвэрлэлийн төв”-д суралцах хүсэлт гаргасан **29** иргэнийг хамруулахаар тогтож, урилгыг гардуулсан байна.

Тайлант хугацаанд “Жендэрийн эрх тэгш байдал, хүний эрх”, “Ажлын байран дахь жендэр”, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”, “Жендэрт суурилсан хүчирхийлэл”, “Гэр бүлийн хүчирхийлэл”, Гэмт хэрэг ба зөрчил”, “Хүний эрх ба Жендэрийн тэгш байдал”, “Ажлын байрны бэлгийн дарамт”, “Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал”, “Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, үл тэвчих орчинг бүрдүүлэх”, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Жендэрийн хэвшмэл ойлголт”, “Жендэрийн тухай ойлголт, хүйсийн ялгаатай байдлыг хүндлэх соёлыг төлөвшүүлэх нь”, “Гэр бүлийн харилцаа”, “Байгууллагын үйл ажиллагаанд жендэрийн дүн шинжилгээ хийх нь” сэдэвт сургалтуудыг 407, 413, 415, 419, 421, 423, 427, 429, 433, 437 дугаар нээлттэй, хаалттай хорих ангиуд, Дорноговь, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг дахь ШШГГ, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь ШШГХ, СМДӨАЭХХГ-д тус тус зохион байгуулсан байна.

Мөн Мэргэжлийн сургалт-Үйлдвэрлэлийн төв нь Удирдлагын академиас зохион байгуулсан “Ахисан түвшний Жендэрийн дүн шинжилгээ” сургалтад **9** алба хаагч хамруулсан байна.

Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги-алба хаагчдын гэр бүлийн гишүүдийг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан бол Орхон аймаг дахь ШШГГ-437 дугаар нээлттэй хорих анги нь ХЗДХЯ болон Азийн хөгжлийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд 50 м² өрөөг зан үйлийн сургалт явуулах зорилгоор тохижуулсан байна.

Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч Б.Оюунгэрэл нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 409 дүгээр хаалттай хорих ангийн алба хаагчдад “Монгол хүний хүйсийн харьцаа болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгэм дэх оролцоо, тэдний дундаж наслалт, эрүүл мэнд, гэр бүлийн харьцаа” сэдвээр уулзалт, ярилцлага хийсэн бол Говь-Алтай аймаг дахь ШШГГ-ын алба хаагчдад “Жендэрийн эрх тэгш байдал болон гэр бүлийн үнэ цэнэ, харилцаа, хандлага” сэдвээр сургалт зохион байгуулсан байна.

Байгууллагын онцлог, үйл ажиллагааг иргэдэд сурталчилан ШШГБ-д ажиллах хүсэлтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх талаар:

Байгууллагын онцлог, үйл ажиллагааг иргэдэд сурталчлан ШШГБ-д ажиллах хүсэлтэй иргэдийн тоог нэмэгдүүлэх чиглэлээр нийт анги байгууллагууд орон нутгийн цэргийн анги, салбарын хугацаат болон гэрээт цэрэг, ЕБС-ийн төгсөх ангийн сурагчидтай уулзалт зохион байгуулж ажилласан байна. Тухайлбал:

421 дүгээр нээлттэй хорих анги, Баянзүрх дүүргийн 10 хорооны 142 дугаар сургуулийн 12 дугаар анги төгсөгчдөд байгууллагын болон ахлагчийн сургуулийн талаарх мэдээллийг өгч яриа таниулга хийж, гарын авлага тараасан байна.

Дорноговь аймаг дахь ШШГГ нь орон нутагт байрлах ХЦ-ийн 0168 дугаар анги болон харьяа заставуудаар 2022.03.20-03.25-ны өдрүүдэд явж, хугацаат цэрэг болон гэрээт цэргийн бие бүрэлдэхүүнд байгууллагын үйл ажиллагааны онцлог, харуул хамгаалалтын ажилтан бэлтгэх сургалтын талаар яриа таниулга хийж сурталчилсан байна.

Өвөрхангай аймаг дахь ШШГГ-423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги 2022.03.30-ны өдөр Хархорин сумын “Номын хүрдэн”, “Орхон цогцолбор сургууль”, “Гүнзгий сургууль”, ЕБ-ын II сургуулийн 12 дугаар ангийн сурагчидтай тус тус уулзалт хийж ДХИС-ийн Ахлагчийн сургууль болон ОХУ-ын тэтгэлэгт сургалтын талаар мэдээлэн суртчилах ажлыг зохион байгуулан ажилласан байна.

Хамгаалалтын ажилтны сул орон тоог нөхөх зорилгоор Зэвсэгт хүчний 015 дугаар анги, Зэвсэгт хүчний 017 дугаар ангиуд, эмч, сувилагчийн сул орон тоог нөхөх зорилгоор АШУҮИС-ийн оюутны хөгжил, удирдлагын газарт хамтран ажиллах саналыг албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

Мөн Этүгэн их сургуулиас зохион байгуулсан ажил олгогч аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг “Хүндэтгэлийн лекц” өдөрлөгт оролцон, төгсөгчдөд ШШГБ-ын талаар танилцуулж, ажилд орохыг хүссэн 83 төгсөгчийн товч анкетыг авч танилцсан байна.

Байгууллагын сул орон тоог нөхөх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулах талаар:

ДХИС-ийн Ахлагчийн сургуулийг төгссөн 90, ОХУ-ын ДХЯ-ны харьяа Удирдлагын академийг төгссөн 1, ДХИС-ийн ШШГА-ны сургуулийг төгссөн 1, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 4 нийт **96** иргэнийг шинээр албан тушаалд томилсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад **3186** алба хаагч үүрэг гүйцэтгэж байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар шинээр 209 иргэнийг, төрийн албаны мерит зарчмыг баримтлан 154 алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэн, 287 алба хаагчийг шилжүүлэн томилсон байна.

Байгууллагын сул орон тоог нөхөх зорилгоор өмнөх оны нөөцөд бүртгэлтэй ДХИС-ийн ШШГА-ны сургуулийн 7 сонсогч, Ахлагчийн сургуулийг төгссөн 46, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 27 иргэнээс нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулан ажиллаж байна.

ШШГБ-ын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх.--- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор 2022 онд нийт 159 орон тоо нэмэгдсэнээс ШШГЕГ-ын даргын 2022.02.09-ний өдрийн А/23, А/24, А/25, А/26, А/27, А/28, А/29, А/30 дугаар тушаалуудаар Хорих ял эдлүүлэх албанд 61, Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газарт 8, Шийдвэр гүйцэтгэх албанд 14, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд 40, “Соёмбо” чуулгад 36 орон тоо тус тус хуваарилсан байна.

Алба хаагчдын цахим сургалтын талаар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдыг үндсэн ажил үүргээс нь хөндийрүүлэлгүйгээр тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг сайжруулах зорилгоор дараах агуулгын хүрээнд сургалт зохион байгуулсан байна. Үүнд:

1. Харилцааны менежмент суурьтай сургалтын модулийн хүрээнд 6 цаг;
2. Сэтгэл зүй суурьтай сургалтын модулийн хүрээнд 4 цаг;
3. Албан бичиг боловсруулалт суурьтай сургалтын модулийн хүрээнд 4 цаг;
4. Манлайлал, ур чадвар суурьтай сургалтын модулийн хүрээнд 8;

Анги байгууллага, салбар нэгжийн цахим сургалтыг нийт 13 удааг 26 цагийн хичээл орж, сургалтад анги, байгууллагын 24.450 /давхардсан тоогоор/ алба хаагч цахимаар, 628

/давхардсан тоогоор/ алба хаагч танхимын хэлбэрээр тус тус хамрагдсан байна.

Төрөл мэргэжлийн алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтын талаар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/218 дугаар тушаалаар батлагдсан хөтөлбөрт тусгагдсан хуваарийн дагуу дараах төрөл мэргэжлийн алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд:

- Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны техник хяналтын ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад нийт 30;
- Хорих анги, байгууллагын нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтад нийт 60;
- Хорих анги, байгууллагын ахлах төлөөлөгч, төлөөлөгч нарыг мэргэшүүлэх сургалтад нийт 91;
- Хорих анги, байгууллагын сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтад нийт 118;
- Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн хүний тоо бүртгэлийн байцаагч, туслах нарыг мэргэшүүлэх цахим сургалтад нийт 67 алба хаагч тус тус хамрагдсан байна.

“Хүмүүн байхын учир ёс суртахуунд нь оршвой” сэдвээр Монгол Улсын Төрийн шагналт, Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, академич, МУИС-ийн Эмерит профессор, Япон Улсын Нагояагийн Их сургуулийн хүндэт доктор Содовсүрэнгийн Нарангэрэл 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр 2 цагийн сургалт орсон.

2022 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 14 удаагийн 28 цагийн хичээл сургалтад хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, салбар нэгжийн 24.450 /давхардсан тоогоор/ алба хаагч цахимаар хамрагдсан байна.

Төрийн байгууллагуудын цахим санг “Үндэсний Дата төв УТҮГ”-т байршуулах Засгийн газрын 146 дугаар тогтоол, мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмын хүрээнд “ШШГЕГ-ын сургалт”-ын програмыг байршуулах тухай хүсэлтийг уламжлан surgalt.cd.gov.mn цахим хаягийг үүсгэж, эрх авсан програмын боловсруулалтын бэлтгэл ажил хийж байна.

Алба хаагчдын англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд батлагдсан “Гадаад хэл- мэдлэгийн түлхүүр” дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийн биелэлтийг хангах талаар:

Гадаад хэл-мэдлэгийн түлхүүр” дунд хугацааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг батлан, анги байгууллагад хүргүүлж, дүн шинжилгээ хийн ажилласан байна.

Тайлант хугацаанд анги байгууллагууд орон нутаг дахь гадаад хэлний сургалтын байгууллага, ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, төрийн бус байгууллагын багш нартай хамтран ажиллах гэрээ байгуулан, сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулж хэвшжээ.

Гадаад хэлний мэдлэг, хэрэглээний чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөөний дагуу өнгөрсөн, одоо, ирээдүй цаг, хавсарсан, нийлмэл болон тодотгол өгүүлбэр, шинэ үг, бусад дүрэм, унших, бичих, сонсгол, дуудлага засах, нийтлэг хэрэглэгддэг болон мэргэжлийн шинэ үг, дүрэм цээжлэх, шинэ үг, бусад дүрмийн **10** цагийн лекц, унших, бичих, сонсгол, дуудлага засах **25** цагийн семинар, нийтлэг хэрэглэгддэг болон мэргэжлийн шинэ үг, дүрэм цээжлэх **10** цагийн бие даалт нийт **45** цагийн хичээл сургалтыг зохион байгуулахад **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагдсан байна.

Нийт анги байгууллага, салбар нэгжийн 3001 алба хаагчийн англи хэлний мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгааг авч нэгтгэхэд эхлэн суралцагч 1981 буюу 66%, анхан шатны мэдлэгтэй 837 буюу 27.9%, дунд шатны мэдлэгтэй 179 буюу 6%, ахисан түвшний мэдлэгтэй 4 буюу 0.1% үзүүлэлттэй дүгнэгдсэн байна.

Гадаадын зарим орны ижил чиг үүргийн байгууллагатай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар:

ОХУ-ын Холбооны ял эдлүүлэх албатай 2021-2023 онд хамтран ажиллах санамж бичгийн дагуу 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн саналыг холбогдох албадуудаас авч нэгтгэн хүргүүлсэн байна.

Бүгд Найрамдах Турк Улсын Элчин сайдын яамаар дамжуулан тус улсын хорих байгууллагуудын удирдах газартай хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцааг бэхжүүлэх зорилгоор айлчлал хийх саналыг хүргүүлэхэд тус байгууллагаас саналыг дэмжин урилга ирүүлсэн байна.

Дээрх урилгын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга болон түүний дагалдах төлөөлөгчид 2022 оны 10 дугаар сарын 23-наас 30-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Турк Улсын Пробацийн алба болон түүний харьяа цахим хяналт тавих чиг үүрэг бүхий төвийн үйл ажиллагаатай танилцах, харьяа нээлттэй, хагас нээлттэй, хаалттай хорих ангийн үйл ажиллагаатай танилцах, алба хаагчдын сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах албан айлчлал хийхээр бэлтгэл ажлыг хангасан байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсын ижил чиг үүргийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэх чиглэлээр холбогдох танилцуулга, судалгаа, орчуулгыг боловсруулан найрсаг харилцаа тогтоох чиглэлээр албан бичгийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад харилцааны яамаар уламжуулан хүргүүлсэн байна.

Ази, Номхон бүс нутгийн хорих байгууллагуудын удирдах ажилтны бага хурал 2022 оны 09 дүгээр сард Сингапур улсад цахим хэлбэрээр зохион байгуулагдахаар шийдвэрлэгдсэн байна.

Тус бага хуралд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг төлөөлөн цахим хэлбэрээр оролцох алба хаагчийн илтгэл, судалгаа, холбогдох танилцуулгыг боловсруулж хүргүүлсэн байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн хорих багууллагуудын удирдах ажилтны бага хурал 2022 оны 09 дүгээр сарын 19-ны өдрөөс 23-ны өдөр Сингапур Улс цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд ШШГБ-г төлөөлөн ШШГЕГ-ын даргын ахлах даалгавар гүйцэтгэгч, хурандаа Ц.Очгэрэл, Гадаад харилцаа, хэвлэл мэдээллийн хэлтсийн дарга, хошууч А.Цэнгэл, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Б.Амаржаргалан нар оролцсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд “Монгол Улсын хорих байгууллагын нийгмийн ажилтан болон сэтгэл зүйч нарын чадавхыг бэхжүүлэх” сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулан “КОЙКА” олон улсын байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлсэн байна.

“ЖАЙКА” олон улсын байгууллагаас 2022 оны 07 дугаар сард зохион байгуулах “Хорих ангийн удирдлага зохион байгуулалт, хоригдлыг нийгэмшүүлэх асуудал” сэдэвт сургалтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас алба хаагчийг оролцуулахаар бэлтгэн ажлыг хангаж байна.

“ЖАЙКА” олон улсын байгууллагаас 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 29-ны өдрийн хооронд зохион байгуулж буй “Хорих ангийн удирдлага зохион байгуулалт, хоригдлыг нийгэмшүүлэх асуудал” сэдэвт сургалтад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг төлөөлөн Нээлттэй 423 дугаар ангийн сэтгэл зүйч а/д М.Тэлмэн оролцсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан талаар:

АТГ-ын Олон нийтийн төвийн сургалтад ШШГЕГ-ын 150, санхүүгийн асуудал хариуцсан мэргэжилтэн 2, нийт **152** алба хаагчийг хамруулсан байна.

Тайлант хугацаанд шинэчилсэн мэдүүлэг гаргасан **790** алба хаагчийн мэдүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 07/429 дүгээр албан бичгээр АТГ-т хүргүүлсэн. Тайлант хугацаанд шинээр, шилжин болон дэвшин томилогдсон **222**, их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн **7** нийт **1019** алба хаагчаас ХАСХОМ-ийг гаргуулан цахимд баталгаажуулж, эрх бүхий албан тушаалтнаар дэвшин, шилжин томилогдсон **12** алба хаагчид эрх үүсгэн өгч, нууцын баталгааг гаргуулан авсан байна.

Хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 07/2715 дугаар албан бичгээр өгсөн “2022 оны мэдүүлгийн бэлтгэл ажлыг хангах тухай” үүргийн биелэлтийг дүгнэхэд хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой 2 зөрчил илэрсэн тул тухайн нэгжийн даргын тушаалаар нэр бүхий 2 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан байна.

3. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

Хорих болон хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны бүртгэл, хяналтын системийн хөгжүүлэлтийг хийж сайжруулах хүрээнд Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний бүртгэл хяналтын нэгдсэн системийг шинэчлэх чиглэлээр хийгдэх ажлын даалгаврыг боловсруулсан байна.

Тайлант хугацаанд “Цахим бүртгэл, хяналтын систем”-д хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн нийт 45185 /ажиллагаатай 3346, хасагдсан 1348, дуусгавар болгосон 40491/ ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан нийт 29320 /хяналтад байгаа 3116, дуусгавар болсон 25261, хасагдсан 943/ этгээдийн мэдээлэл бүртгэгдсэн байна.

Хорихоос өөр төрлийн ялын бүртгэл, хяналтын системд бүртгэгдсэн ялтнуудад холбогдох мэдээллийг сар бүрийн мэдээ, судалгаатай тулгалт хийж, хяналт тавин ажилласан байна.

БНХАУ-ын “Shenzhen Hexun Technology Co.,LTD” компаний туршилтад ашиглагдах 2 ширхэг гарын цахим бугуйвч, 2 ширхэг хөлийн цахим бугуйвч, 2 ширхэг гэрийн хорионы суурин

станц, 2 ширхэг зөөврийн цэнэглэгчийн үнэ болох 935 ам.долларын хяналтын тоног төхөөрөмжийг хүлээн авч, туршилтын журмаар ажиллаж байна.

АЕГ нь шинэчлэгдсэн төрийн архивын систем (www.e-document.gov.mn)-ийг 2022 оны 03 дугаар улиралд тусгай болон төрөлжсөн архивуудад суурилуулахаар төлөвлөсөн бөгөөд тус төрийн архивд 2022 оны 12 дугаар сард суурилуулахаар ажиллаж байна.

Ньюсоник ХХК-ны “EDOC” архив, албан хэрэг хөтлөлтийн системийг ШШГЕГ-ын харьяа 53 байгууллагад 2022 оны 08 дугаар сараас шинээр нэвтрүүлж, Мэдээлэл технологийн хэлтсээс хөмрөг үүсгэгч байгууллагуудад хаяг, нэвтрэх эрх олгон, 2023.01.01-ээс үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан байна.

Мөн шинээр нэвтрүүлж буй “Edoc” системийн хүрээнд “Албан хэрэг хөтлөлтийн системийн модуль”, “Архивын системийн модулийн ашиглалт, нэвтрүүлэлт” сэдвээр архив, бичиг хэргийн ажилтнуудад цахимаар сургалт зохион байгуулсан байна.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Хил хамгаалах ерөнхий газар, “Хас” банктай мэдээлэл солилцох ажлыг цахим хэлбэрт шилжүүлэх хүрээнд Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газартай хамтран ажиллах гэрээг байгуулж, төлбөр төлөгчийн газрын мэдээллийг цахим хэлбэрээр солилцох ажлыг нэвтрүүлсэн байна.

Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөртэй эсэх тодорхойлолт, лавлагааг Төрийн худалдан авах ажиллагааны газрын Tender.gov.mn цахим хаягаас Голомт банкны цахим хуудас болон аппликейшнээр дамжуулан олгох ажлыг нэвтрүүлж, Голомт банктай гэрээг шинэчлэн байгуулсан байна.

Төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авах, битүүмжлэх, суутгал хийх ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Хаан банк, Ариг банктай хамтран ажиллах гэрээг тус тус байгуулсан байна.

Гадаадад зорчих эрх түдгэлзүүлэх, сэргээх санал гаргах ажиллагаатай холбоотой зөвлөмжийг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 09/346 дугаар албан бичгээр нэгжүүдэд хүргүүлж, аргачлалаар хангасан. Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллахаар 2021 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах, хилээр нэвтрэх эрх түдгэлзүүлсэн нийт 5974 төлбөр төлөгчдийн холбогдох мэдээллийг жагсаалтаар гарган хүргүүлсэн байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээллийн сангаас тусгай зөвшөөрлийн эрхийн мэдээллийг цахим хэлбэрээр солилцох, хамтран ажиллах албан бичгээр хүргүүлж, төлбөр төлөгч хуулийн этгээдийн нэр болон тусгай зөвшөөрлийн дугаараар хайлт хийн, хүчинтэй тусгай зөвшөөрлийн лавлагааг цахим хэлбэрээр авах ажиллагааг нэвтрүүлсэн байна.

ШШГЕГ-ын цахим хуудасны бүтэц, агуулгыг шинэчилж, хандалтыг нэмэгдүүлэх. Харьяа анги, байгууллагын цахим хуудасны үйл ажиллагааг боловсронгуй болгож,

мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Цахим хуудсыг шинэчлэн боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, даалгаврыг гүйцэтгэхээр “Веб мастерууд” ХХК, “Гөүсмарт” ХХК, “Ухаалаг шийдэл” ХХК, “Содонсолюшн” ХХК, “Грийнсофт” ХХК, “Модисофт” зэрэг компаниудаас үнийн санал

авсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим хуудаст нээлттэй мэдээллийг байршуулах ажлыг тогтмол хийж, одоогийн байдлаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын

тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийг цахим хуудаст шинэчлэн байршуулсан бөгөөд бусад мэдээллийг шинэчлэхээр ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn сайтад 147, фэйсбүүк хуудаст 326, дотоод мэдээллийн самбарт 132 мэдээ, мэдээллийг тус тус боловсруулан байршуулсан байна.

Мөн байгууллагын фэйсбүүк хуудасны онлайн чатаар хандсан 336 иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, сургалтын чиглэлээр асуусан асуултад хариу мэдээллийг цаг тухай бүрт нь өгч ажилласан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын www.cd.gov.mn цахим хуудаст давхардсан тоогоор 133,159 иргэн хандалт хийсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага фэйсбүүк хуудасны хандалт 2,201,306, дагагчийн тоо 2691-ээр нэмэгдэж, нийт 39,168 болсон байна.

Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх хүрээнд

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан, олон нийтэд хүргэх ажын хүрээнд МҮОНРТ, Монгол HD, TV9, TV5, TV8, SBN, ETV, Eagle, NTV, 25-р суваг, C1 телевизэд нийт давхардсан тоогоор 24 удаагийн мэдээ;

“Өдрийн сонин”, “Үндэсний шуудан”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ” сонинд 21 удаагийн мэдээ, “Үндэсний шуудан” сонинд сурвалжилга 1, ярилцлага 1, мэндчилгээ 2 удаа;

News.mn, gogo.mn, ergelt.mn, npost.mn, zindaa.mn, zaluu.mn, ubn.mn, asu.mn, nnews.mn, etime.mn, time.mn, eguur.mn, medee.mn, urug.mn, ikon.mn, arslan.mn, tsahiur.mn, urug.mn, isee.mn, 24tsag.mn, dardas.mn сайтад 131 удаагийн мэдээ;

Алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг харуулсан фото сурвалжилгыг бэлтгэн niitlel.mn, snews.mn, etime.mn, asu.mn, zaluu.mn, urug.mn, npost.mn, tsahiur.mn, asu.mn, zaluu.mn, npost.mn сайтад тус тус 14 удаа нийтлүүлж, олон нийтэд хүргэсэн. Монголын үндэсний олон нийтийн радиогийн Хуульзүйн “Соёмбо” шууд нэвтрүүлэгт 1 удаа оролцож, зорчих эрхийн хязгаарлах ялын хэрэгжилтийн талаар иргэдэд холбогдох мэдээллийг өгсөн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөөг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тодорхой ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулсан байна. Тухайлбал:

Улсын хэмжээнд 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, нэгжүүд тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргын тамгын газартай хамтран нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтнаар нийтийн эзэмшлийн болон авто замын дагуух ногоон байгууламжийг цэвэрлүүлж, зэрлэг ургамлыг зулгааж, хадах ажлыг эхлүүлсэн. Энэ талаарх видео мэдээг бэлтгэн байгууллагын пэйж хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэсэн байна.

200 га талбайн зэрлэг ургамлыг түүж цэвэрлэсэн талаарх мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны <https://mojha.gov.mn/>, epress.mn, tac.mn, onlinetv.mn, tsahiur.mn, niitlel.mn, ubn.mn, atime.mn, snews.mn, gogo.mn сайт, “Өнөөдөр сонин”-ы №169 (7471)

дугаарт тус тус нийтлүүлсэн.

Иргэд, олон нийтэд хууль, эрх зүйн мэдлэг олгох зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвөөс “Хөтөч” подкастыг “Тэжээн тэтгэх үүрэг ба хүүхдийн тэтгэлэг” сэдвийн хүрээнд бэлтгэн байгууллагын пэйж хуудаст байршуулсан байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлэх. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд үндэсний 12 телевиз, өдөр тутмын 4 сонин, 21 сайттай хамтран ажилласнаар давхардсан тоогоор нийт 155 мэдээ, мэдээллийг бэлтгэн үнэ төлбөргүй нийтлүүлсэн байна.

4.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар:

Зөрчлийн болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Иргэний

болон

захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тухай хуулиудыг тус тус ШШГТХ-тай харьцуулан судалж шинэчлэн найруулсан болон хасагдсан, зарчмын зөрүүтэй байдлын саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/71, А/72, А/73 дугаар тушаалуудаар Иргэний болон захиргааны хэргийн, Зөрчлийн болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тухай хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсгийг байгуулж,

тус ажлын хэсгийн тушаалыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/93, А/94 дүгээр тушаалаар хуулийн төслүүдийг боловсруулах дэд ажлын хэсгүүдийг байгуулсан.

“Эрүү, зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухай хууль”-ийн төслүүдэд харьяа алба, газар, хэлтэс, салбар нэгжүүдээс санал авч ирсэн саналуудыг нэгтгэн удирдлагад танилцуулан хуулийн төслүүдэд тусгасан бөгөөд хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, зардлын тооцоо, үр нөлөөг үнэлэх тайланг тус тус боловсруулсан байна.

ШШГБ-ын эрх зүйн шинэтгэлийн 2021-2024 оны дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

1. 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгохоор болсонтой холбогдуулан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын төслийг боловсруулсан.

2. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар “Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм”-ийг

баталсан бөгөөд тус тогтоолын хавсралтын 17-д 435 дугаар хаалттай хорих ангийн байршлыг “Дархан уул аймаг, дархан сум” гэж заасныг өөрчлөн, хорих ангийн нутаг дэвсгэрийн байршлыг зөв тодорхойлж

“435 дугаар хаалттай хорих анги, Сэлэнгэ аймаг, сайхан сум” гэж өөрчлүүлэх саналыг ХЗДХЯ-нд хүргүүлснээр Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 170 дугаар тогтоолоор "Дархан-Уул аймаг, Дархан сум" гэснийг "Сэлэнгэ аймаг, Сайхан сум" гэж өөрчилсөн.

3. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар 17-ны өдрийн чуулганы хуралдаанаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэн баталлаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төрийн цэргийн байгуулалд хамрагдах эрх зүйн орчин бүрдсэнээр байгууллагын статус, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн эрх зүйн байдал зэрэг нь бусад төрийн цэргийн байгууллагатай нэгэн адил болж, Монгол Улсын хэмжээнд цэргийн албаны чиглэлээр батлагдсан гарсан хууль, дүрэм, журмыг мөрдөх үндсэн нөхцөл бүрдэж байгаа юм. Түүнчлэн бусад нэмэлт өөрчлөлтөөр 2002-2018 онд шийдвэр гүйцэтгэгчийн энгийнээр ажилласан хугацааг цэргийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцох, зорчих эрхийг хязгаарлах ял эдэлсэн хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс бус ялтанд гав зүүсэн үеэс эхлэн тоолох, баривчлах төв болон байранд ажиллаж буй алба хаагчдыг хорих байгууллагын алба хаагчтай адилтган үзэх нөхцөл бүрдсэн байна.

Баривчлах шийтгэлийг ШШГБ үе шаттай хэрэгжүүлэхтэй холбогдуулан хорих ангийн харуул хамгаалалтын журамд нэмэлт өөрчлөлт оруулах :

2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр 623 дугаар дотоод албан бичгээр:

- Ял эдлүүлэх ажиллагаанд мөрдөгдөж буй хорих байрны дотоод журам,
- Хорих ангийн харуул хамгаалалтын журам,
- Баривчлах байрны дотоод журам, албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалтын журам,
- Шалган нэврүүлэх үйл ажиллагаа, үзлэг нэгжлэгийн стандарт,
- Хоригдсон этгээдийн эрхийг хангахад чиглэсэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх ажиллагааны стандарт,
- Ялтныг хуяглан хүргэх ажлын зааварт тус тус нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловруулсан.

2022 оны 09 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тухай хууль”, “Эрүү, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн төсөлд санал авах хэлэлцүүлгийг Хорих ял эдлүүлэх албаны хаагчдын дунд зохион байгуулж төслийн саналыг боловсруулсан.

Иргэний, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах. Иргэний, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах.

Шийдвэр гүйцэтгэгчдийн IV нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах. Шийдвэр гүйцэтгэгчдийн нэгдсэн 4 дүгээр зөвлөгөөн, хэлэлцүүлгийн хөтөлбөр, шаардагдах зардлын тооцооллыг гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

ХЗДХЯ-наас зардлын санхүүжилтийг Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолд нийцүүлэн боловсруулж, дахин танилцуулах чиглэлийг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 3/1402 дугаар албан бичгээр ирүүлсэний дагуу төсвийг хянаж тооцсон байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулан ХЗДХЯ-нд хүргүүлэх. “Зөрчлийн болон эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн төсөлд хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааны чиглэлээр тусгах санал, томъёоллыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Төсөлд зарчмын шинжтэй дараах нэмэлт өөрчлөлтүүдийг тусгуулахаар санал хүргүүлээд байна. Үүнд:

- ял эдлэхээс оргон зайлсан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг эрэн сурвалжлах ажиллагаа, эрэн сурвалжилж албадан ирүүлсэн ялтан, этгээдийг дахин оргон зайлахаас урьдчилан сэргийлж оногдуулсан ял, албадлагын арга хэмжээг шийдвэрлүүлэх хүртэл прокурорын тогтоолоор 72 цаг хүртэл хугацаанд саатуулах,

- хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлэх,

- хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг нийгэмшүүлэх, сургалт нөлөөллийн ажил, түүний төрөл, хэлбэр, явуулах аргачлал,

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа нэгжгүй нутаг дэвсгэрт оршин суух зорчих эрх хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтанд харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавих,

- эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох, өөрчлөх, сунгах процесс болон гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх харуул хамгаалалтын үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг шинээр нарийвчлан тусгасан.

Мөн хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг хүлээн авах, хяналтын хувийн хэрэг нээх, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг дуусгавар болгох зэрэг нийтлэг зохицуулалтуудыг нэгтгэсэн байна.

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах:

Зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр цахим хэлэлцүүлгийг 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдөр Дархан-Уул аймагт зохион байгуулж, тус хэлэлцүүлэгт Дархан-Уул аймгийн прокурор, цагдаагийн байгууллага, аймгийн засаг даргын тамгын газрын хуулийн хэлтэс, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Архангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал сум дахь Шүүхийн

шийдвэр гүйцэтгэх хэлтсийн хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан 20 гаруй алба хаагчдын төлөөлөл оролцсон байна.

Хэлэлцүүлгээс олон улсын тэргүүн туршлагыг судлах, зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангахад шаардлагатай программ хангамж, шаардлага хангасан үзүүлэлт бүхий цахим бугуйвчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, шуурхай албаны ажилтны орон тоог

нэмэгдүүлэх, ялаас оргон зайлах үеийн эрэн сурвалжлах ажиллагааны журам, ялын хэрэгжилтийг хангах явцад үүсч буй түр саатуулах тусгайлсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх нэгжийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх, ажиллагааны зардал, техник хангамжийг шийдвэрлэх зэрэг саналыг дэвшүүлсэн байна.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын ачаалалд дүн шинжилгээ хийж, ачааллыг тэнцвэржүүлэх талаар холбогдох санал боловсруулах:

Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилт хариуцсан алба хаагчдын ажлын ачаалалд дүн шинжилгээ хийж, ачааллыг тэнцвэржүүлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр санал боловсруулж, улсын хэмжээнд **НИЙТ 43** /Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албанд 7, аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хэлтэст ахлах шийдвэр гүйцэтгэгч 15, шийдвэр гүйцэтгэгч 12, шуурхай албаны ажилтан 7, албадан сургалт хариуцсан мэргэжилтэн, техник хяналтын ажилтан тус бүр 1/ орон тоог нэмж шийдвэрлүүлсэн байна.

Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилт хариуцсан алба хаагчийн орон тоог нэмж шийдвэрлүүлснээр хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгчийн ажлын ачаалал буурах, хуулиар хүлээсэн чиг үүрэг бүрэн хэрэгжих, хорихоос өөр төрлийн ял шийтгэлийн бодлого хангагдах зэрэг эерэг нөлөө үзүүлж байна.

Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилтийг хангах, эрүүгийн ялын бодлогыг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор албадан эмчлэх эмнэлэг болон хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний хэрэгжилт хариуцсан алба хаагчдын ажлын ачаалал, нормативыг шинэчлэх саналыг танилцуулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.

Мөн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор тус албаны болон харьяа газар, хэлтсүүдийн орон тоо, албан тушаалын нэршил, зэрэглэлд өөрчлөлт орсон тул ажлын байрны шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны даргын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/05 дугаар тушаалаар байгуулж, нийт 45 албан тушаал дээр албан тушаалын тодорхойлолтыг батлан, үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, журмын эмхэтгэлийг гаргаж, алба хаагчдыг гарын авлагаар хангах. Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам, зааврын эмхтгэлийн төслийг боловсруулж, 100 ширхэгийг хэвлүүлсэн

Албадан эмчлэх эмнэлгийн барилгын зураг төслийг гаргуулах;

Эмнэлгийн барилга барихад шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэх саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх. Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн барилгыг шинээр барих бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан байна. Үүнд:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Таширын хөндийд 300 орны багтаамж, хүчин чадал бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн барилга барих 150 га газар, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэрэгцээнд ашиглах 10 га газрыг Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас шилжүүлэн авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/75 дугаар тушаалаар “газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах” чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсэг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хуралдаж, ажлын хэсгийн гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, зардлын талаар хэлэлцэн, сонгосон газар дээр үйл ажиллагаа явуулж байсан 6 иргэний 16 га газарт байршсан модон хашааг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж дууссан байна.

66 айлын газрын кадастрын зургийг хийлгэхээс 45 иргэний кадастрын зургийг хийлгэж, 21 иргэний кадастрын зургийг хийлгэх ажил үргэлжилж байна.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас шилжүүлэн авах 150 га газрын бичиг баримтыг бүрдүүлэн Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд газар эзэмших гэрчилгээг гаргуулах хүсэлтийг 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 10/668 дугаар албан бичгээр;

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр Таширын хөндийн 150 га газрыг Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөнд тусгуулах саналыг 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 10/666 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн барилгын зураг төслийг боловсруулах зургын даалгаврыг боловсруулж, Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын яамнаас эмнэлгийн барилгын зураг, төсөл боловсруулах аж ахуй нэгжийг шалгаруулах нээлттэй тендерийг зарласан. Тендерийн 2 дахь шатны шалгаруулалт үргэлжилж байна.

Тус албадан эмчлэх төрөлжсөн эмнэлгийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих саналыг 2023 оны төсвийн төсөлд тусган Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.

5.ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГАД ХЭРЭГЖИЖ БАЙГАА ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТАЛААР:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх 2020-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “Хүний нөөцийн бодлогын хөгжлийг бэхжүүлэх 2020-2024 оны дунд хугацааны хөтөлбөр”-ийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн, зарим хэрэгжүүлсэн ажлыг багцлан дурдвал,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 166 алба хаагч, 491 ахмад ажилтан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар 329, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар 1070 алба хаагчийг шагнаж урамшуулсан. “Цэргийн цол олгох журам”-ын дагуу цэргийн цол хоорондын хугацааг баримтлан тэмдэглэлт баярыг тохиолдуулан харьяа газар, хэлтэс, албадуудаас ирүүлсэн санал, тодорхойлолтыг үндэслэн өнөөдрийн байдлаар эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан

521 алба хаагчийг цэргийн ээлжит цол, 51 алба хаагчид


хугацааны өмнө цэргийн цол олгож, 45 алба хаагчийн урьд хэрэглэж байсан цолыг сэргээсэн, 28 алба хаагчийн сахилгын шийтгэлийг хугацааны өмнө сахилгын шийтгэлгүйд тооцсон, мөн шинээр 306 алба хаагчид цол олгосон байна.

Тайлант хугацаанд нийт хорих анги, байгууллага, салбар, нэгж нь **61** цагийн лекц, **135** цагийн семинар, **79** цагийн бие даалт нийт **275** цагийн хичээл сургалтад **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагдаж, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан байна.

ШШГЕГ-ын даргын 2020 оны А/96 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу системийн хэмжээнд нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд **59,7** сая төгрөг, тэтгэврийн зардалд **1629,9** сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Анги, байгууллагын хэмжээнд нийт 107 алба хаагчид 13.675.000 төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлжээ. - 419 дүгээр нээлттэй хорих анги, 441 дүгээр нээлттэй хорих анги, Баривчлах байр нь алба хаагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор бялдаржуулах өрөө тохижуулсан бол Завхан аймаг дахь ШШГГ нь алба хаагчиддаа зориулж “Хүүхэд харах өрөө”-г шинээр бий болгосон байна.

Зураг-1.Хүүхдийн өрөөний зургууд



2. “2022 онд зохион байгуулах алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр”

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/218 дугаар тушаалаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд 2022 онд зохион байгуулах алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр”-ийг батлан, анги байгууллага, салбар нэгжид хүргүүлж, сар бүр сургалтын тайлан мэдээг авч нэгтгэн, үүрэг чиглэл өгч, удирдлага зохион байгуулалтаар ханган

ажиллаж байна.

Хорих анги, байгууллага, салбар нэгжүүд нь тайлант хугацаанд **15** цагийн лекц, **20** цагийн семинар, **15** цагийн бие даалт нийт **50** цагийн хичээл сургалтыг зохион байгуулахад **56** анги, байгууллагын **2350** алба хаагч хамрагдсан байна.

Бие бялдрын бэлтгэлжилтийг хангах сургалтын хүрээнд **40** цагийн семинар, **14** цагийн бие даалт нийт **60** цагийн хичээл сургалтыг нийтлэг зохион байгуулжээ. Нийт **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагдсан байна.

Галт зэвсэг, тусгай хэрэгслэлийн дадлага сургалтын хүрээнд **10** цагийн лекц, **20** цагийн семинар, **20** цагийн бие даалт нийт **50** цагийн хичээл сургалтыг **56** анги байгууллагын **2350** алба хаагч хамрагджээ.

Сургалтын тоглолт, команд штабын сургалт, дадлага сургалтын хүрээнд хүрээнд **10** цагийн лекц, **10** цагийн семинар, **10** цагийн бие даалт нийт **30** цагийн хичээл сургалтыг **12** анги байгууллагын **960** алба хаагч хамрагдсан байна.

Гадаад, дотоодын их дээд сургууль, удирдлагын академийн бакалавр, магистр, удирдлага, докторын сургалтад алба хаагчдыг хамруулан, чадавхыг бэхжүүлэх.---- Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд байгууллагын захиалгаар Москва хотын Удирдлагын академийн адъюнктурт 1 /ахмад Н.Эрдэнэбулган/, магистрантурт 3 /ахмад Ц.Баттулга, хошууч Т.Даваасүрэн, ахмад Б.Содбаяр/, Москва хотын их сургуулийн сэтгэл зүйн бакалаврын хөтөлбөрт 4 / дэд ахлагч С.Чингүн, А.Марал, Х.Мөнх-Амгалан, Б.Одхүү/, ОХУ-ын Волгоград хотын их сургуулийн эрх зүйн бакалаврын хөтөлбөрт 2 /дэд ахлагч Э.Индра, С.Сэрчмаа/, Санктпетербург хотын академийн сэтгэл зүйн бакалаврын хөтөлбөрт 4 Екатеринбург хотын Уралын их сургуулийн эрх зүйн бакалаврын хөтөлбөрт 2 нийт **22** алба хаагч суралцаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд ашиглах алба хаагчдын сургалтын цахим вэб хуудас шинээр үүсгэн, үйл ажиллагаанд нэвтрүүлж, ажлын байранд зайнаас суралцах нөхцөлийг бүрдүүлж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны

12 дугаар сарын 30-ны өдрийн А/218 дугаар тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2022 онд зохион байгуулах сургалтын хөтөлбөр"-ийг батлуулан, нийт анги, байгууллагуудад хүргүүлж, сар бүр сургалтын тайлан мэдээг авч нэгтгэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан байна.

2022 онд алба хаагчдад зохион байгуулах сургалтыг танхимын, цахим, мэргэшүүлэх сургалт гэсэн 3 төрлөөр явуулсан байна.

Сургалтын тайланг 2022 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэхэд харьяа анги, байгууллагууд сургалтын хөтөлбөрийн хүрээнд алба хаагч бүрийг хөгжүүлэх, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн танхимын хичээл сургалтын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

6.ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар тус ерөнхий газарт 134 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг иргэд, аж ахуй нэгжээс тус тус хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Нэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт ирсэн өргөдөл, гомдол

Тус ерөнхий газарт 73 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс 40 хүсэлт, 33 гомдол хүлээн авсан. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой 30, албан хаагч болон иргэнээс 33 өргөдөл, гомдол тус тус хүлээн авсан байна.

Нийт өргөдөл гомдлын 39.7 хувь шийдвэрлэгдэн хариу хүргүүлсэн. 61,3 хувь нь хяналтын шатанд байна. Өнөөдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдолгүй байна.

дд	Алба, газар	Нийт	Шийдвэрлэж хариуг хүргүүлсэн	Хяналтанд байгаа	Хугацаа хэтэрсэн
1.	Захиргааны удирдлагын газар	29	14	15	-
2.	Шийдвэр гүйцэтгэх алба буюу бусад газар	26	10	16	-
3.	Хорих ял эдлүүлэх алба	2	1	1	--
4.	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба	-	-	-	
5.	Санхүү, үйлдвэр хөрөнгө оруулалтын газар	5	1	4	-
6.	Хяналт шалгалт, аюулгүй байдлын газар	11	1	10	-
	Нийт	73	27	46	-

Хоёр. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөс ирсэн өргөдөл, гомдол

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс 11 дүгээр сарын 01-нээс 15-ны өдрийн хооронд 44 өргөдөл, гомдлыг хүлээн авч ажилласан. Үүнээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой 41, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 3 өргөдөл гомдол ирсэн. Өнөөдрийн байдлаар хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй. Ирж буй талархлын тоо нэмэгдсэн байна.

Шийдвэрлэж хариу өгсөн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийхэд ирсэн 21 нь үндэслэлтэй, 9 нь үндэслэлгүй гарсан өргөдөл гомдол байна. Үүнд:

- Төлбөр авагчийн гаргасан 4 нь үндэслэлтэй, 1 нь үндэслэлгүй;

Төлбөр төлөгчийн гаргасан 3 нь үндэслэлтэй, 1 нь үндэслэлгүй гаргасан гомдол байна. Өнөөдрийн байдлаар нийт 45 өргөдөл, гомдол хяналтын шатанд байна. Өргөдөл, гомдлыг 14 хоногоор харьцуулахад өргөдөл гомдол 4.5 хувиар өссөн байна.

Өргөдөл, гомдлыг бууруулахаар шуурхай ажил зохион байгуулснаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлт энэ онд 88,5 хувьтай байсан 11 сарын эхний 14 хоногийн байдлаар 52.7 хувийн шийдвэрлэлтэй байна.

Үүнд: талархал-5, хүсэлт-3, гомдол-34 ирсэн. Ирж байгаа өргөдөл, гомдлын 88.1% нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой, 11,9% нь бусад асуудлаар ирсэн өргөдөл, гомдол байна.



Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 10.15-10.30-ны өдрийн байдлаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлт урд 58,7 хувийг шийдвэрлэн иргэнд хариуг өгч байсан бол өнөөдрийн байдлаар 48 шийдвэрлэх шатандаа шийдвэрлэлт 62,3 хувьтай байна.



Гурав. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цахим хаягаар ирсэн өргөдөл, гомдол

Тус газрын цахим хаягаар 17 өргөдөл, хүлээн авсан. Үүнд: Хоригдож байгаа талаар-1, хорих байгууллагын үйл ажиллагааны талаар-2, шийдвэр гүйцэтгэгчийн ёс зүйтэй холбоотой-1, хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой-3, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эрчимжүүлэх-10 өргөдөл, гомдол хүлээн авсан байна..

7.ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЛААР

7.1. НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР



Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 оны батлагдсан орон тоогоор Захиргаа, санхүү болон Иргэний шийдвэр гүйцэтгэлийн 11 хэлтэс, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтэс, Шийдвэр гүйцэтгэлийн тоо бүртгэлийн хэлтэс, Эрэн сурвалжлах хэлтэс гэсэн бүтэцтэй, 197 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Захиргаа:
 - Дарга, Тэргүүн дэд дарга
 - Сургалт, Хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн-1
 - Ахлах нягтлан бодогч -2,
 - Тооцооны нягтлан бодогч-3,
 - Нярав-2,
 - Архив бичиг хэргийн ажилтан-1,
 - Архивын ажилтан-1,
 - Дуудлага худалдаа хариуцсан ажилтан-1,
 - Мэдээлэл лавлагаа хариуцсан ажилтан-1,
 - Автын механик-1, жолооч -10,
 - Аж ахуйн ажилтан-1, үйлчлэгч-3, цахилгаанчин-1
2. Иргэний шийдвэр гүйцэтгэл:
 - Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан дэд дарга -2,
 - Хэлтсийн дарга бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч -11,
 - Шийдвэр гүйцэтгэгч -91
3. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтэс:
 - Хэлтсийн дарга-1,
 - Тасгийн дарга бөгөөд ахлах шийдвэр гүйцэтгэгч-4,

- Шийдвэр гүйцэтгэгч -29,
 - Бусад ажилтан-6
4. Шийдвэр гүйцэтгэлийн тоо бүртгэлийн хэлтэс:
- Хэлтсийн дарга-1,
 - Тоо бүртгэлийн ахлах мэргэжилтэн-1,
 - Гүйцэтгэх хуудас бүртгэл лавлагааны ажилтан-6,
 - Мэдээллийн технологийн инженер-1
5. Эрэн сурвалжлах хэлтэс:
- Хэлтсийн дарга-1,
 - Эрлийн ахлах ажилтан-2,
 - Туслах ажилтан-4,
 - Хамгаалалтын ажилтан-3, нийт 197 орон тоотой.

Үүнээс иргэний ахлах шийдвэр гүйцэтгэгч-2, шийдвэр гүйцэтгэгч-4, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн ахлах шийдвэр гүйцэтгэгч-1, шийдвэр гүйцэтгэгч-3, механик-1, жолооч 4, үйлчлэгч 1 орон тоо дутуу байна. Өнөөдрийн байдлаар 183 ажилтан, албан хаагчидтайгаар Нийслэлийн 6 дүүрэгт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 оны 10 дугаар сарын 20-ны мэдээгээр:

- Оны үлдэгдэл 1,0 их наяд төгрөгийн үнийн дүнтэй 10341 гүйцэтгэх баримт бичиг;
- Шүүхээс ирсэн 1,2 их наяд төгрөгийн үнийн дүнтэй 12256 гүйцэтгэх баримт бичиг;
- Харьяаллаар шилжижи ирсэн 156,4 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 3588 гүйцэтгэх баримт бичиг;
- Түдгэлзүүлсэн болон дууссан, буцаасныг сэргээсэн 133,8 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 1016 гүйцэтгэх баримт бичиг;
- Хасагдсан 613,8 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 4677 /түдгэлзүүлсэн, төлбөр авагчид буцаасан, шилжүүлсэн./ гүйцэтгэх баримт бичиг;
- Биелүүлбэл зохих 2,2 их наяд төгрөгийн үнийн дүнтэй 22524 гүйцэтгэх баримт бичиг;
- 527,9 тэрбум төгрөгийг бодитой биелүүлж, 8756 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгон, 1,7 их наяд төгрөгийн 13765 гүйцэтгэх хуудасны үлдэгдэлтэй байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 38,9 хувьтай, мөнгөн дүнгийн биелэлт 23,5 хувьтай ажилласан.

НИЙТ ГҮЙЦЭТГЭХ БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭ

Д/Д	Оны үлдэгдэл	Шүүхээс ирсэн	Шилжиж ирсэн	Түд, буцаасан, дууссаныг сэргээсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл	Бодит биелэлтийн хувь
г/х	10341	12256	3588	1016	4677	22524	8759	13765	38,9

1.	м/ д	1,0 их наяд	1,2 их наяд	156,4 тэрбум	133,8 тэрбум	613,8 тэрбум	2,2 их наяд	527,9 тэрбум	1,7 их наяд	23,5
----	---------	-------------------	-------------------	-----------------	-----------------	-----------------	-------------	-----------------	-------------------	------

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Д/Д	Оны үлдэгдэл	Шүүхээс ирсэн	Шилжиж ирсэн	Түд, буцаасан , дууссан ыг сэрсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл	Бодит биелэлтийн хувь	
1	г/х	153	122	27	1	34	269	101	168	37,5
	м/ д	19,3 тэрбум	474,4 сая	3,0 тэрбум	0	3,0 тэрбум	19,7 тэрбум	439,3 сая	19,3 тэрбум	2,2

ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Д/Д	Оны үлдэгдэл	Шүүхээс ирсэн	Шилжиж ирсэн	Түд, буцаасан , дууссан ыг сэрсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Биелүүлсэн	Үлдэгдэл	Бодит биелэлтийн хувь	
1	г/х	827	799	11	16	28	799	620	162	79.7
	м/ д	4,1 тэрбум	3,6 тэрбум	196,8 сая	341,7 сая	732.2 сая	3.4 тэрбум	1,6 тэрбум	511.6 сая	84.9

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх чиглэлээр

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтэс нь 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт 9403 гүйцэтгэх баримт бичигт эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 5721 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгон 3682 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй ажилласан байна. Үүнд:

Торгох ялын биелүүлбэл зохих 7.2 төгрөгийн 4402 гүйцэтгэх баримт бичгээс 2.9 тэрбум төгрөгийн 3170 ялын гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, 268 сая төгрөгийн 251 гүйцэтгэх баримт бичгийг өршөөлийн хуульд хамруулж, 808 гүйцэтгэх хуудасны 691.4 сая төгрөгийг хэсэгчлэн биелүүлж, 10 ялтан нас барж, 50 ялтны ялыг хорих ялаар солин 921 гүйцэтгэх хуудасны 3.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын биелүүлбэл зохих 782 гүйцэтгэх баримт бичгээс 423 ялтны ялыг бүрэн эдлүүлж, 82 ялтныг өршөөлийн хуульд хамруулан шийдвэр гүйцэтгэх

ажиллагааг дуусган 106 ялтныг эрэн сурвалжлан олж тогтоон хорих ялаар солин 169 ялтны үлдэгдэлтэй байна.

Эрх хасах ялын биелүүлбэл зохих 885 гүйцэтгэх баримт бичгээс 121 ялтны ялыг дуусгаж, 56 ялтныг өршөөлийн хуульд хамруулан, 6 ялтан нас барж, 702 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй байна.

Зорчих эрх хязгаарлах ялын биелүүлбэл зохих 1409 гүйцэтгэх баримт бичгээс 494 ялтны гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгон 1 ялтныг өршөөлийн хуульд хамруулж, 9 ялтанд холбогдох гүйцэтгэх баримт бичгийг шүүхээс хүчингүй болгон, 10 ялтан нас барж, 208 ялтныг эрэн сурвалжлан олж тогтоох хорих ялаар сольж 686 гүйцэтгэх баримт бичгийг үлдэгдэлтэй байна.

Тэнсэх албадлагын арга хэмжээ авагдсан нийт 1918 гүйцэтгэх баримт бичиг Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 719 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгон 862 этгээдийн үлдэгдэлтэй бөгөөд хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан 64 гүйцэтгэх баримт бичгийн 5.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр хийгдсэн ажлуудаас:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлж, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор шат дараатай арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд:

Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс 2022 оны 02 дугаар сард бүтэц орон тоонд өөрчлөлт оруулан 24 орон тоог шинээр нэмэгдүүлсэн боловч нийслэл дэх хүн амын төвлөрөл, шинээр гудамж, хороо нэмэгдэх зэрэг олон хүчин зүйлээс хамаарч ажлын бодит ачааллыг ажлын байрны зураглал хийн тодорхойлж жишиг нормативыг шинээр тогтоож, шийдвэр гүйцэтгэгчийн орон тоог нэмэгдүүлэх саналыг Хууль зүй, дотоод хэргийн яамны дэд сайдад 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 1/13096 тоот албан бичгээр шийдвэр гүйцэтгэх албанд хүргүүлсэн. Дотоод нөөц бололцоондоо тулгуурлан 1 давхрын үүдний хэсэгт өрөө гаргаж өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн, архив бичиг хэргийн ажилтан, зөвлөлийн хурлын өрөөнд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн даргыг, 3 давхарын өрөөнд Хан-Уул дүүргийн 3 шийдвэр гүйцэтгэгчийг оруулж нийт 11 алба хаагчийг ажиллах орчин нөхцөлөөр ханган ажиллаж байна Мөн шинээр томилогдсон алба хаагчдад Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм, үйлчилгээний стандарт сэдвээр 2 цагийн сургалт, цэрэгжилт, жагсаалч байдал, цэргийн дүрмээр 2 цагийн сургалт, мөн Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн алба, цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалтыг зохион байгуулсан байна.

Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулах санал хүргүүлэх:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/95 тоот тушаалаар Иргэн болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр

хуулийн төсөл боловсруулах дэд ажлын хэсэгт дэд дарга, дэд хурандаа С.Бямбарагчаа, ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахмад Б.Даваадорж, ахлах дэслэгч Э.Батхишиг нар томилогдон ажиллаж, Хуулийн тандан судалгааны тайлан, үр нөлөөний тайлан, зардлын тайлан, хууль батлуулах хэрэгцээ шаардлагын тайланг гаргаж хууль зүйн яаманд хүргүүлсэн байна.

Төлбөр төлөгч, түүний хөрөнгийн мэдээллийг цахим хэлбэрээр хүлээн авах, эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох Төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийн эрхийг түдгэлзүүлсэн 702, сэргээсэн 514, мөн төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, лавлагаа авсан 184 лавлагааг холбогдох газарт хүргүүлж, 10507 төлбөр төлөгчийн арилжааны банк дахь данс битүүмжлэх, хасалт хийх мэдэгдэл, 3767 төлбөр төлөгчийн данс сэргээх тогтоолыг арилжааны банкуудад хүргүүлэн ажилласан байна.

7.2.ШШГЕГ-ЫН ХАРЬЯА 421 ДҮГЭЭР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИ

ШШГЕГ-ын харьяа 421 дүгээр нээлттэй хорих анги нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн

/хуучин нэрээр/ 1965 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 333 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн хэрэгцээний төмс, хүнсний ногооны зоорь барих зорилгоор барилгын анги нэртэйгээр анх байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Бүтэц орон тоо:

Тус анги нь орон тоо, цалингийн сангаар төсвөөс 71, дотоод орлогоор 5, нийт 76 орон тоотой батлагдсан. Өнөөдрийн байдлаар 70 алба хаагч ажиллаж, хамгаалалтын ажилтан 4, авто, тоног төхөөрөмжийн механик -1, жолооч-1, орон тоо дутуу байна.

Анги нь захиргаа-санхүү, харуул хамгаалалтын алба гэсэн 2 үндсэн бүтэцтэй, офицер 24, ахлагч 46 албан хаагч байгаагаас 49 нь эрэгтэй, 21 нь эмэгтэй.

Захиргаа-санхүүгийн алба нь ангийн дарга, ХХГАЭ дэд дарга, ахлах нягтлан бодогч, СХНХМДАХ ахлах мэргэжилтэн, нягтлан бодогч-2, нярав-2, жолооч-3, тогооч, аж ахуйн ажилтан, авто тоног төхөөрөмжийн механик, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, архив, бичиг хэргийн ажилтан гэсэн 18 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй.

Харуул хамгаалалтын алба нь ахлах төлөөлөгч, төлөөлөгч-2, харуул хамгаалалтын ахлах байцаагч, нийгмийн ахлах ажилтан, нийгмийн ажилтан-2, сэтгэл зүйч, хуяглан хүргэлтийн ажилтан, тогооч, тоо бүртгэлийн байцаагч, тоо бүртгэлийн туслах-2, холбоочин-4, ерөнхий жижүүр-4, хамгаалалтын ажилтан-32, их эмч, сувилагч-4 гэсэн 58 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байгаагаас хамгаалалтын ажилтан-4, холбоочин-1 ажлаас гарах өргөдөл гаргаж шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байна.

Тус анги байгуулагдсан цагаасаа хойш давхардсан тоогоор 20 гаруй мянган алдаж эндсэн иргэдийг хүлээн авч, тэднийг сурган хүмүүжүүлж, хөдөлмөрийн чиг баримжаа олгон хөдөлмөрлүүлэн ухааруулж нийгэмд нь эргэн нэгтгэжээ.


Харуул хамгаалалтын чиглэлээр:

Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор харуул хамгаалалтыг 3 ээлжээр

зохион байгуулсан. Харуул хамгаалалтын нэг ээлж нь ерөнхий жижүүр-1, холбоочин-1, сувилагч-1, хамгаалалтын ажилтан-5 нийт 8 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр үүрэг гүйцэтгэж байна.

Ээлжийн бие бүрэлдэхүүнийг ангийн дарга, харуул хамгаалалт, гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга нар өдөр бүр үүрэг даалгавар, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ээлж хүлээлцүүлж, ээлжийн бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлтэд ангийн удирдлага болон харуул хамгаалалтын ахлах байцаагч, төлөөлөгч нар тогтмол хяналт тавьдаг. Харуул хамгаалалтын бүрэлдэхүүнийг хүн нэг бүрийн агсамж, тусгай хэрэгслээр /гав, бороохой, энгэрийн камер, цахилгаан бороохой, гар станц/ хангасан байна.

Хоригдлын хөдөлгөөн байршилд нийт 115 телекамераар тогтмол хяналт тавин ажиллахаас ажиллагаатай 106 телекамер байгаа бөгөөд холбоочид аналог системийн 11, IP системийн 95 телекамераар, 1-р шалган нэвтрүүлэх байрны хамгаалалтын ажилтан IP системийн 5, 2-р шалган нэвтрүүлэх байрны хамгаалалтын ажилтан аналог системийн 1, IP системийн 4 телекамераар тус тус хөдөлгөөнийг хянадаг бөгөөд 9 телекамер шинээр авч шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.



/телекамеаар хяналт тавих дэлгэцийн харагдах байдал /

Амьдралын бүс рүү гаднаас орох, гарах хаалгыг соронзон түгжээ суурьлуулж, телекамераар гадна болон дотор талыг хянах дэлгэц, хаалга онгойлгох удирдлагыг ШНБ-нд байрлуулж, хамгаалалтын ажилтан бүрэн хянаж ажиллаж байна.



/Соронзон түгжээ бүхий хаалга, хянах дэлгэц/

Хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар нь ганцаарчлан уулзаж, хоригдлын хувийн хэрэг холбогдох материалтай танилцан хоригдлын нас, үйлдсэн гэмт хэрэг, хувийн онцлогт тохируулан сургалт нөлөөллийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн а/207 дугаар тушаалаар батлагдсан “Хорих ял эдлэх үеийн жишиг хөтөлбөр”-ийн хүрээнд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар нь “Амьдрах ухаан”, “Зан үйлд нөлөөлөх албадан сургалт”, “Эрүүл мэнд”, “амьжиргааны түвшин дээшлүүлэх”, “Хууль эрх”

багц сургалтуудыг үе шаттайгаар ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна.

Нийт хоригдлыг сургаж, хөдөлмөрийн чиг баримжаа олгох, мэргэжил эзэмшүүлэх, сэтгэл зүй, зан байдалд нь эерэг төлөвшил бий болгоход анхаарч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын “Амгалан” мэргэжил сургалт үйлвэрийн төвтэй хамтран 4 мэргэжлээр 100 хоригдол мэргэжил эзэмших сургалтад хамрагдаад байна. Мөн хорих ангитай хамтран “Сэтгэлийн боловсрол”, “Тунараа аз жаргалын төв”, “Гандан тэгчлэн хийд”, Баянзүрх дүүргийн насан туршийн боловсролын төв” гэх төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.



/Сургалт явагдаж буй байдал/

Хоригдлыг ажлын байраар хангаж хөдөлмөрлүүлэх, тэдний нийгэм иргэдэд учруулсан хохирол төлбөрийг барагдуулах, ажлын дадлага туршлага, хөдөлмөрийн чиг баримжаа олгох нь хорих ангийн үндсэн чиг үүргийн нэг мөн.

Тус анги нийт хоригдлын 40 орчим хувийг хамтарсан аж ахуй нэгж, байгууллагад гэрээний үндсэн дээр ажиллуулж цалинтай ажлын байраар хангаж ирсэн бөгөөд хоригдлуудыг ШШГЕГ-ын харьяа Хэрэмт цамхаг УТҮГазарт хөнгөн бетон үйлдвэрлэх, “Чиглэл” ХХК-д нийтийн хоолны тоног төхөөрөмж угсралт, Экспресс” ХХК-д чулууны үйлдвэрлэх ажилд хөдөлмөрлүүлэхийн зэрэгцээ аж ахуй нэгж байгууллагад гэрээгээр туслах ажилтнаар ажиллуулж цалин хөлс олгож байна.



Хоригдлыг хөдөлмөрлүүлэх нь тэдэнд мэргэшил, хөдөлмөрийн чиг баримжаа олгож цаашлаад хорих ангиас суллагдсаны дараа сурсан мэдсэн зүйл, олж авсан хөдөлмөрийн дадал туршлагаараа амьдрал ахуйгаа хөтлөх, нийгмийн хамтын аж байдлын хэв ёс, хууль тогтоомж зөрчихгүйгээр хэвийн амьдрахад чухал хөшүүрэг болдог байна.

Тус ангид нийт-253 хоригдол ял эдэлж байгаагаас тусгай-212, энгийн-41 хоригдол байна. Үүнээс гадаадын харъяат 7, хар тамхины гэмт хэрэг үйлдсэн 6 онцгой анхаарал татсан 17, эмчийн хяналтанд 75 /анхаарал татсан өвчтэй 14, хүндэвтэр-2, тогтмол эмчийн хяналтанд байдаг 59/ хоригдол байна.

2022 оны 10 дугаар сарын 20-ны байдлаар шинээр 174, хорих анги шилжиж ирсэн 23, ялд өөрчлөлт орж ирсэн 4, өсвөр насны хоригдол насанд хүрч 4, нэгдсэн эмнэлэгт эмчлүүлж ирсэн 289, хугацаа дуусч суллагдсан 25, хугацааны өмнө суллагдаж, хяналт тогтоогдсон 80, дуудлагаар 6, нэгдсэн эмнэлэгт эмчлүүлэхээр явсан 295, хорих анги сольж явсан 5, өршөөлийн хуульд хамрагдаж ял сольсон 3, шийтгэх тогтоол хүчингүй болж 1 хоригдлын хөдөлгөөн хийгдсэн байна.

Өнөөдрийн байдлаар:

- “Хэрэмт цамхаг” УТҮГ-т нэр бүхий 22 хоригдол “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын алба хаагчдын харуул хамгаалалтад;

- “Төр хур” амралт сувиллын газарт үүрэг гүйцэтгэх хамгаалалтын ажилтныг 14 хоног бүрийн даваа гарагт сольдог ба одоогоор нэр бүхий 3 хоригдол хамгаалалтын ажилтан, дэд ахлагч С.Алтангэрэлийн хяналтад;

- Төв аймгийн Лүн суманд байрлах малын хэсэгт 2 хоригдлыг хамгаалалтын ажилтан, дэд ахлагч Б.Маналжав хяналтад.

- Дорноговь аймгийн Угтаал сумын Ханги боомт төмөр замын хэсэгт 19 хоригдлыг төлөөлөгч, ахмад Э.Хангай, хамгаалалтын ажилтан, ахлах ахлагч Д.Хүрэлбаатар, дэд ахлагч З.Амартүвшин, дэд ахлагч Б.Бат-Эрдэнэ нарын хяналтад

Хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар:

2022 оны 9 дүгээр сарын байдлаар хоригдол ажиллуулах гэрээний дагуу давхардсан тоогоор 253 хоригдлыг хөдөлмөр эрхлүүлж Хэрэмт цамхаг УТҮГ-аас 35,523,175.97, “Чиглэл” ХХК-аас 99,576,280, “Оюут констракшн”-аас 10,630,000, Налайх ШШГГазраас 2,000,000, Цагдан хорих 461-р ангиас 9.240,000, “Эксперсс зам” ХХК-аас 4,240,000, “Будлан хайрхан”-аас 5,469,000, “Эрдэнэ хэв хашмал” ХХ-аас 1,500,000, 405-р хаалттай хорих ангиас 3,000,000, “Гранддрим” ХХК-аас 1,800,000 нийт 183,941,975.97 төгрөгийн цалин бодогдсоноос татварт 18.394.197 төгрөгийг суутган үлдэгдлийг нэрийн дансанд төвлөрүүлэн ажилласан байна.

68 хоригдлын цалин хөлснөөс 20.249.575 төгрөгийг шүүхийн төлбөрт шилжүүлж, 132 хоригдлын хөдөлмөрийн хөлснөөс хүсэлтийн дагуу ар гэрт нь 37.317.457 төгрөг тус тус шилжүүлэн, ангийн аж ахуй үйлчилгээнд нэр бүхий 8 хоригдлыг ажиллуулан хөдөлмөрт тохирсон шагналын хоногийг сар бүр олгон ажилласан байна.

7.3 ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАРИВЛАХ ТӨВ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн б/741 дүгээр тушаалаар Баривчлах төвийн бүтэц, орон тоог 44 орон тоотойгоор баталсан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/30 дугаар “Орон тоо нэмэх тухай” тушаалаар шинээр 3 орон тоог нэмж нийт 47 орон тоотойгоор шинэчлэгдэн батлагдсан.

Баривчлах төв нь хууль тогтоомж болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий даргын хууль, журамд нийцүүлэн гаргасан тушаал, шийдвэрийн хүрээнд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Зөрчлийн тухай хуулийн холбогдох хэсгийг зөрчин шүүгчийн шийтгэврээр оногдуулсан баривчлах шийтгэлийг биечлэн эдлүүлж зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг зохион байгуулах чиглэлээр;

ШШГЕГ-ын даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/58 дугаар “Баривчлах шийтгэл эдлүүлэх харьяалал тогтоох тухай” тушаалын дагуу Нийслэлийн 5 дүүрэг, мөн даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/97 дугаар “Баривчлах шийтгэл эдлүүлэх харьяаллыг шинэчлэн тогтоох тухай” тушаалын дагуу Нийслэлийн 6 дүүргийн ЭХАШШүүхийн шүүгчийн шийтгэврээр Зөрчлийн тухай хуулийн 9 зөрчилд холбогдон 10-50 цагийн албадан сургалтад хамруулах, **7-30** хоногийн хугацаагаар баривчлах шийтгэлийг биечлэн эдлүүлэхээр шийтгэгдсэн /2022 оны 11 дүгээр сарын 08-ны байдлаар 3976 этгээдийг “Баривчлах байрны дотоод журам”-д заасны дагуу хүлээн авч хууль, баривчлах шийтгэлийг биечлэн эдлүүлж, батлагдсан төлөвлөгөөний дагуу албадан сургалтыг /ганцаарчилсан, бүлгийн, цахим, танхимын хэлбэрээр/ зохион байгуулж байна.

2. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих чиглэлээр;

2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн ШШГЕГ-ын дарга, ЦЕГ-ын дарга нарын хамтарсан А/98, А/131 дүгээр тушаалаар СЭМҮТ-ийн ШСЭСК-ийн харуул хамгаалалтын чиг үүргийг хүлээн авсан бөгөөд өнөөдрийн байдлаар эрэгтэй 26, эмэгтэй 13 нийт 39 албадан эмчлүүлэгч шүүхээс тогтоосон эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж харуул хамгаалалт, аюулгүй байдлыг ханган зөрчил дутагдалгүй ажиллаж байна

3. Согтууруулах мансууруулах донтой өвчтөнг албадан эмчилгээнд хамруулах шүүхийн шийтгэврийг биелүүлэх чиглэлээр;

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/127 дугаар “Баривчлах байрны дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаалын 21.3 дахь хэсгийн биелэлтийг ханган 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар Архины албадан эмчилгээнд хамруулах **182** өвчтөнг хүлээн авч журмын дагуу дамжин өнгөрүүлсэн.

7.4 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ 445 ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИ

Тус анги нь 1991 онд Монгол Улсын Засгийн Газрын 153 дугаар тогтоолоор Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэд жирийн дэглэмтэй Хорих 435-р ангийг 25 алба хаагчтайгаар хуучин цэргийн ангийн байрлалд байгуулсан нь Дархан-Уул аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх алба-Хорих 445 дугаар ангийн үндэс болсон түүхтэй.

1996 онд батлагдсан Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай Монгол улсын хуулийн дагуу Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 1999 оны А/169 дүгээр тушаалаар шүүхийн бүрэлдэхүүнд багтан үйл ажиллагаа явуулдаг байсан шийдвэр гүйцэтгэлийн хэсгийг тус хорих ангитай нэгтгэн шийдвэр гүйцэтгэх алба болгон өргөжүүлсэн байна.

2002 онд Монгол улсад өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиуд шинэчлэн батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн Газрын 155 дугаар тогтоолоор Дархан-Уул аймгийн Засаг Даргын дэргэдэх Цагдаагийн газрын харьяанд байсан Цагдан хорих байрыг 2002 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр хүлээн авч харуул хамгаалалтыг зохион байгуулж эхэлсэн ба 2003 онд хуульд шинээр туссан баривчлах

ял эдлүүлэх 45 хүний багтаамжтай жишиг байрыг барьж тохижуулан ашиглалтад оруулсан байна.

2007 онд Монгол Улсын Засгийн Газрын 188 дугаар тогтоолоор Хорих 435-р ангийг **Онцгой дэглэмтэй** хорих анги болгон өөрчилсөн. Иймд олон улсын жишигт нийцсэн төвлөрсөн хорих анги байгуулах зорилгоор албаны төвд 160 хүний багтаамж бүхий хоригдлын хоёр давхар шинэ байр барьж 2007 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан.

2008 оны 07 дугаар сард уг байрны гадуур 1,5 метр суурийн гүн, 5 метр өндөр бүхий 365 метр урт хамгаалалтын хэрмэн хашааг барьж дуусгасан.

Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 312 дугаар тогтоолын дагуу Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын даргын 2009 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/99 дүгээр тушаалаар жирийн дэглэмтэй “**Хорих 445 дугаар анги**”-ийг шинээр тус албаны харьяа болгосон түүхтэй.

2017 оны 06 дугаар 09-ний өдөр батлагдсан Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх тухай хуульд зааснаар тус ангийн нэршил нь **нээлттэй хорих анги** болж өөрчлөгдсөн. Дээрх хуульд Нээлттэй хорих анги нь **энгийн** болон **тусгай** зэрэглэлтэй байхаар хуульчлагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн өдрийн Б/1076 дугаар тушаалаар **Дархан-уул аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих анги** нэршилтэй болсон.

Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-445 дугаар нээлттэй хорих ангийн даргаар дэд хурандаа С. Лхагвасүрэн ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар нээлттэй хорих анги, цагдан хорих байр, иргэн, эрүүгийн шийдвэр гүйцэтгэл гэсэн үндсэн 3 чиглэлд 84 орон тоотойгоор хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн, үйл ажиллагаа явуулж байна.

Зураг:

1

СУРАН ЭДЛЭЛ



ГАР УРЛАЛ

Зураг 2,3,4,5,





7.5 ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН 409 ДҮГЭЭР ХААЛТТАЙ ХОРИХ АНГИ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 409 дүгээр хаалттай хорих анги нь 1997 онд Барилгын үйлдвэрлэлийн ашиглалтын өмнөх захиргаа нэртэйгээр анх байгуулагдсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 98 дугаар тогтоол, ШШГЕГ-ын даргын 2000 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 99 дүгээр тушаалаар “Хорих 409 дүгээр анги” нэршилтэйгээр байгуулагдсан байна.

Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нэгдсэн хорихын барилга барих, бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэхээр Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 130 дугаар тогтоолоор тус хаалттай хорих анги нь одоогийн байрлалд ирж Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 1447 тоот зөвшөөрлийн дагуу “409 дүгээр хаалттай хорих анги” гэсэн нэршил бүхий хаалттай хорих ангийн зохион байгуулалттайгаар хуулийн хүрээнд ажиллаж байна.

Ангийн бүтэц орон тоо: Батлагдсан орон тоогоор нийт 140 алба хаагчтай, 16 сул орон тоо байна. Үүнд:

- Офицер-5
- Ахлагч-73
- Эрэгтэй- 84
- Эмэгтэй -40
- Дээд боловсролтой-77
- Тусгай дунд бодовсролтой -4
- Бүрэн дунд боловсролтой-43 байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хэсэг

Тус ангийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хэсэг нь эрүүл мэндийн хувьд анхаарал татсан, хөдөлмөрийн чадвараа түр болон удаан хугацаагаар

алдсан, байнгын

асаргаа сувилгаа шаарддаг хоригдол, хоригдогч нарт байнгын эмчилгээ үйлчилгээг нэгдсэн эмнэлгийн тусламжтайгаар үзүүлэн ажилладаг байна.

Уг хэсэг нь 1 их эмч, 6 сувилагчийн бүрэлдхүүнтэй бөгөөд 40-45 хоригдолыг эмчилгээ үйлчилгээнд хамруулан ажиллаж байна .

Хоригдолыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд:

- Сургалт
- Нөлөөлөл
- Сэтгэл зүй
- Хөдөлмөрийн дадал олгох

Хорих ангид хүлээн авч хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил

- Анхан шатны мэдээлэл цуглуулах
- Санал хүсэлт авах
- Хорих ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгуулах
- Хорих өрөөнд хуваарилан хорих ял эдлүүлэр үеийн нийгэмшүүлэх ажил

Суллагдахаас өмнө үеийн хорих ял эдлүүлэх үеийн нийгэмшүүлэх ажил

- Суллагдахаас 3 сарын өмнө нийгмийн амьдралд бэлтгэх зорилгоор сургалтад хамруулна
- Гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх
- Суллагдсаны дараа хүлээн авах орчингүй хоригдолыг төрийн болон төрийн бус байгууллагатай холбон зуучлах

Хоригдолын хөдөлмөр эрхлэлт үйлдвэрийн талаар

Тус ангийн хоригдолуудын 80 хувь нь байнгын ажлын байраар хангагдан, цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломжтой байна. Гутлын үйлдвэр, зөөлөн эдлэлийн үйлдвэр, тавилгын үйлдвэрүүдэд ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 358 гаруй сая төгрөгийн цалин бодож олгосон байна.

Дэглэм	Хаалттай тусгай	263	385	401
	Хаалттай энгийн	122		
	Нээлттэй тусгай	16	17	
	Нээлттэй энгийн	1		

8. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН АЛБАН ХААГЧ, ИРГЭДИЙН САНАЛЫГ НЭГТГЭЛИЙН ХЭСЭГ

	2021	2022
1. Үйлчилгээний түргэн шуурхай байдлын дундаж үзүүлэлт	2.8	2.9
2. Хууль хэрэгжүүлэх үүргийн хэрэгжилтийн дундаж үзүүлэлт	2.8	3.0

а. Ерөнхий сэтгэл ханамж

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн үйл ажиллагаа, харьяа байгууллагын үйл ажиллагаа, мэдээлэл, шударга байдлыг 1-5 оноогоор (1 бол маш муу, 5 бол маш сайн) үнэлүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаар судалгаанд хамрагдсан иргэдийн 13% нь мэдэхгүй байна. Үндсэн үйл ажиллагаа, үүргийн талаар мэдэж байгаа иргэдийн сэтгэл ханамжтай байдлын түвшин дундаж хэмжээнд хүрэх хандлагатай байна. Аливаа төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд сэтгэл хангалуун биш, төрд итгэх итгэл суларсан нь судалгааны дүнд нөлөөлсөн байж болох учир энэ асуудлыг харгалзан үзэх ёстой болов уу.

Хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн буурсан үзүүлэлттэй гарсан боловч Мэдэхгүй гэх хариулт 2021 онд иргэдийн 8-11%-ийг эзэлж байсан бол 2022 онд 6-7% болж буурсан эерэг үзүүлэлт гарав.

Энэ хүрээнд тус байгууллагын үүргүүдийг иргэд 2,4-2,8 оноогоор үнэлсэн бол харьяа байгууллагын албан хаагчид болон хуульчид иргэдээс арай илүүгээр буюу 2,8-2,9 оноогоор үнэлжээ. Үзүүлэлт тус бүрээр харвал:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны залгамж холбоог иргэд 2,5, ТАХ, хуульчид 2,8
- Ирсэн санал гомдолд хариу өгөх байдалд иргэд 2,7, төрийн алба хаагч, хуульчид 2,9
- Ажилтан албан хаагчдын харилцаа хандлагад иргэд 2,7, төрийн алба хаагч, хуульчид 2,9
- Үйл ажиллагааны шуурхай байдалд иргэд 2,6 төрийн алба хаагч, хуульчид 2,8
- Авлигаас ангид шударга ажиллаж буйд иргэд 2,4, төрийн алба хаагч, хуульчид 2,8
- Үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ техник технологийн дэвшил ашиглах байдалд иргэд 2,8, төрийн алба хаагч, хуульчид 2,9

- Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох хүмүүст мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх байдалд иргэд 2,7, төрийн алба хаагч, хуульчид 2,
- Хяналт үнэлгээ хийх байдалд иргэд 2,6, төрийн алба хаагч, хуульчид 2,9 оноо өгсөн байна.

Авлигаас ангид, шударга ажиллаж байгаа (2.4), байгууллагын үйл ажиллагааны залгамж холбооны (2.5) үнэлж, техник технологийн дэвшлийг ашиглах байдалд иргэд, төрийн албан хаагч, хуульчид өндөр үнэлгээ өгсөн байна.

Судалгаанд оролцсон иргэдээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын ёс зүйн байдлыг 1-5 оноогоор (1 бол маш муу, 5 бол маш сайн) үнэлүүлж, дундаж үзүүлэлт 3 байхаар тооцож, үр дүнг дундаж үзүүлэлттэй харьцуулсан байдлаар гаргалаа.

Төрийн үйлчилгээний дурдсан 4 бүлэг асуудалд өмнөх онуудад иргэд сэтгэл ханамжгүй буюу дунджаас доогуур гарч байсан бол 2022 оны судалгаагаар бүгд дунджаас дээш үзүүлэлттэй гарсан эерэг дүн гарлаа. Энэ нь 2022 онд хийсэн ажлын үр дүнг шууд харуулж байна.

Иргэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар үйлчлүүлсэн байдалд өгсөн үнэлгээ

		Маш муу	Муу	Дунд	Сайн	Маш сайн	Нийт
Чанар	Үйлчилгээний чанар	7%	13%	38%	39%	4%	100%
	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид асуудлыг нэг удаагийн хандалтаар шийдэж өгөхийг хичээддэг байдал	10%	17%	40%	29%	4%	100%
	Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, мэдлэг	9%	15%	36%	34%	5%	100%
	Хариу мэдээлдэг байдал	13%	18%	37%	24%	8%	100%
	Санал, гомдол илэрхийлэх боломж нээлттэй байдал	11%	21%	34%	28%	6%	100%
	Хүртээмж	Та дээрх үйлчлүүлсэн байгууллагынхаа хүртээмж	6%	12%	45%	33%	4%
	Үйлчилгээний ачааллын хэвийн байдал	6%	13%	45%	32%	4%	100%
	[Үйлчилгээг хэрхэн авах, ямар материал бүрдүүлэх талаар энгийн, ойлгомжтой байдал	5%	18%	37%	34%	6%	100%
	Холбогдох үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай, ил тод байдал / самбар гэх мэт/	6%	18%	42%	28%	5%	100%

Хандсан асуудлын хүрээнд шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг авах боломжтой байдал	6%	16%	41%	32%	5%	100%
--	----	-----	-----	-----	----	------

Харилцаа, ёс зүй	Та дээрх үйлчлүүлсэн байгууллагынхаа алба хаагчийн харилцаа, хандлага	6%	15%	36%	35%	8%	100%
	Ажилтнууд надад туслахад бэлэн байдаг/хандлага/	8%	14%	39%	32%	7%	100%
	Ажилтнуудын эелдэг таатай харилцаа	8%	13%	39%	33%	8%	100%
	Ажилтнууд бүх үйлчлүүлэгчидтэй ижил тэгш харилцах байдал	8%	15%	38%	32%	6%	100%
	Ажилдаа хариуцлагатай ханддаг байдал	8%	10%	43%	31%	8%	100%
	Ажилтнуудын цаг баримтлах, ашиглах байдал	8%	16%	37%	31%	9%	100%
	Шударга байдал /гар харах гэх мэт/	7%	13%	40%	32%	9%	100%
Орчин нөхцөл	Та дээрх үйлчлүүлсэн байгууллагынхаа орчин	3%	12%	43%	36%	6%	100%
	Байгууллагын гадна болон доторх тэмдэг, тэмдэглэгээ харагдахуйц ойлгомжтой байдал	3%	13%	44%	33%	6%	100%
	Үйлчилгээний төвийн доторх үзгэн бал, маягт гэх мэт туслах зүйлсийн хүрэлцээ	3%	16%	43%	32%	7%	100%
	Хүлээлгийн танхим дахь ширээ, сандлын хүртээмж	4%	17%	41%	31%	7%	100%
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал	12%	26%	34%	21%	7%	100%

Иргэд төрийн үйлчилгээ, чанар хүртээмжийг сайнаар дүгнэсэн байна. Үйлчилгээ авсан иргэдийн үнэлэмж өссөн боловч төрийн үйлчилгээний чанар хүртээмж, өмнөх жилтэй харьцуулахад хэр ахицтай байгааг NP Score үнэлгээний аргачлалаар тооцож үзсэн болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг эерэгээр хүлээн авч байна.

8.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мэдээллийн ил тод байдал, хүртээмжийн үнэлгээ

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6-10 дугаар зүйл, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг тогтоох шалгуур үзүүлэлт”-ийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ил тод байдлын үнэлгээг хийхэд

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан, олон нийтэд хүргэх ажын хүрээнд МҮОНРТ, Монгол HD, TV9, TV5, TV8, SBN, ETV, Eagle, NTV, 25-р суваг, С1 телевизэд нийт давхардсан тоогоор 24 удаагийн мэдээ;

“Өдрийн сонин”, “Үндэсний шуудан”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ” сонинд 21 удаагийн мэдээ, “Үндэсний шуудан” сонинд сурвалжилга 1, ярилцлага 1, мэндчилгээ 2 удаа;

News.mn, gogo.mn, ergelt.mn, npost.mn, zindaa.mn, zaluu.mn, ubn.mn, asu.mn, nnews.mn, etime.mn, time.mn, eguur.mn, medee.mn, urug.mn, ikon.mn, arslan.mn, tsahiur.mn, urug.mn, isee.mn, 24tsag.mn, dardas.mn сайтад 131 удаагийн мэдээ; Алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг харуулсан фото сурвалжилгыг бэлтгэн niitlel.mn, snews.mn, etime.mn, asu.mn, zaluu.mn, urug.mn, npost.mn, tsahiur.mn, asu.mn,

zaluu.mn, npost.mn сайтад тус тус 14 удаа

нийтлүүлж, олон нийтэд хүргэсэн байна. Монголын үндэсний олон нийтийн радиогийн Хуульзүйн “Соёмбо” шууд нэвтрүүлэгт 1 удаа оролцож, зорчих эрхийн хязгаарлах ялын хэрэгжилтийн талаар иргэдэд холбогдох мэдээллийг өгсөн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Нийтэд тустай ажил хийлгэх ялын үр нөлөөг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаалаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тодорхой ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Тухайлбал улсын хэмжээнд 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн аймаг, нийслэл дэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, нэгжүүд тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргын тамгын газартай хамтран нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтнаар нийтийн эзэмшлийн болон авто замын дагуух ногоон байгууламжийг цэвэрлүүлж, зэрлэг ургамлыг зулгааж, хадах ажлыг эхлүүлсэн. Энэ талаарх видео мэдээг бэлтгэн байгууллагын пэйж хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэсэн байна.

Мөн тус мэдээг 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн “Өглөөний сонин”-ы №157 (3712), “Өнөөдөр сонин”-ы №165 (7467), “Өдрийн сонин”-ы №158 (7031) дугаарт тус тус нийтлүүлсэн байна.

200 га талбайн зэрлэг ургамлыг түүж цэвэрлэсэн талаарх мэдээг 08 дугаар сарын 24-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны <https://mojha.gov.mn/>, epress.mn, tac.mn, onlinetv.mn, tsahiur.mn, niitlel.mn, ubn.mn, atime.mn, snews.mn, gogo.mn сайт, 08 дугаар сарын 31-ний өдрийн “Өнөөдөр сонин”-ы №169 (7471) дугаарт тус тус нийтлүүлсэн байна.

Иргэд, олон нийтэд хууль, эрх зүйн мэдлэг олгох зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвөөс “Хөтөч” подкастыг “Тэжээн тэтгэх үүрэг ба хүүхдийн тэтгэлэг” сэдвийн хүрээнд бэлтгэн 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр байгууллагын пэйж хуудаст байршуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй хаалттай хорих ангиас хоригдол оргосонтой холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвийн дарга, хошууч Х.Баясгалан 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр ТВ9 телевиз, urug.mn сайтад тодруулга ярилцлага өгсөн байна.

Мөн тус мэдээг zarig.mn, arslan.mn, zindaa.mn, ikon.mn, eguur.mn, ubn.mn, gogo.mn, zogii.mn, dorgio.mn, livetv.mn, urug.mn, gereg.mn, ubn.mn, mnb.mn, unuudur.mn, dardas.mn, isee.mn, ergelt.mn, check.mn, tseg.mn, news.mn, tsahiur.mn, eagle.mn зэрэг 22 сайтад өгч ажилласан байна.

№	Байгууллага	Ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хувиар 2021	Ил тод байдлын шалгуур үзүүлэлт, үнэлгээ хувиар 2022	Харьцуулалт
1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	100	100	хэвийн
	ДҮН	100	100	1,4

8.2. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Нэгдсэн системээс мэдээллийг нэгтгэн харуулбал: Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар мэдээллийг олон нийтэд мэдээллэн ажилласан байна.

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.1-д заасны дагуу төсвийн шууд захирагчаас төсвийн төвлөрүүлэн захирагчид ирүүлсэн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг хүлээн авч, хянан үзээд Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01/373, 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 01/617, 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 01/889, 2022 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 01/1152, 2022 оны 08-р сарын 22-ны өдрийн 01/1770, 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 01/2003 дугаар албан бичгүүдээр урсгал төсвийн зарлагын хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт тус тус гаргасны дагуу “Төсвийн тухай” хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2, 42.2.3-т тус тус заасныг үндэслэн төсвийн урсгал зардлын сар улирлын санхүүжилтийн хуваарьт нийт 6 удаагийн өөрчлөлт оруулан тухай бүр fiscal программд шивж оруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаарыг боловсруулж байгаатай холбогдуулан тус байгууллагын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан 2023 оны төсвийн хязгаарт тусгах саналаа боловсруулан Хууль зүй дотоод хэргийн сайдад хүргүүлсэн байна.

Мөн Хууль зүй дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргад 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/848 дугаар албан бичгээр 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвт тусгуулах төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн саналаа боловсруулан хүргүүлсэн байна.

Харьяа шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, хорих анги, салбар нэгжид 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөллийг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/250 дугаар, ШШГЕГ-ын даргын 2021 оны А/182 тушаалаар тус тус батлагдсан төлөвлөгөөний дагуу 2022 оны худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжүүлэх 4.3 тэрбум төгрөгийн 5 төсөл арга хэмжээ /439 дүгээр хаалттай хорих ангийн спорт заалны барилга, Төв аймаг дахь ШШГГ-ын нэг цонхны үйлчилгээ бүхий цагдан хорих байр, Хэнтий аймаг дахь ШШГГ-ын цагдан хорих байрны барилга, төвлөрсөн хорих ангиудад хөлдөөгч, компьютер техник хэрэгсэл/, урсгал төсвөөс санхүүжих 4.9 тэрбум төгрөгийн 11 төсөл арга хэмжээ, өөрийн хөрөнгөөр санхүүжих 1.8 тэрбум төгрөгийн 6 арга хэмжээ, УТҮГ болон ТӨААТҮГ-уудын 1.9 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагаа болон нийт хорих анги, байгууллагын 7.3 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/- ээр зохион байгуулан ажиллаж байна.

8.3. Хэвлэл, мэдээллийн чиглэлээр хийгдсэн ажлуудаас дурдвал:

Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд үндэсний 12 телевиз, өдөр тутмын 4 сонин, 21 сайттай хамтран ажилласнаар давхардсан тоогоор нийт 155 мэдээ, мэдээллийг бэлтгэн үнэ төлбөргүй нийтлүүлсэн.

News.mn, gogo.mn, ergelt.mn, npost.mn, zindaa.mn, zaluu.mn, ubn.mn, asu.mn, nnews.mn, etime.mn, time.mn, eguur.mn, medee.mn, urug.mn, ikon.mn, arslan.mn, tsahiur.mn, urug.mn, isee.mn, 24tsag.mn, dardas.mn сайтад 131 удаагийн мэдээ; Алба хаагчдын ажил мэргэжлийн онцлогийг аруулсан фото сурвалжилгыг бэлтгэн niitlel.mn, snews.mn, etime.mn, asu.mn, zaluu.mn, urug.mn, npost.mn, tsahiur.mn, asu.mn, zaluu.mn, npost.mn сайтад тус тус 14 удаа нийтлүүлж, олон нийтэд хүргэсэн байна. Монголын үндэсний олон нийтийн радиогийн Хуульзүйн “Соёмбо” шууд нэвтрүүлэгт 1 удаа оролцож, зорчих эрхийн хязгаарлах ялын хэрэгжилтийн талаар иргэдэд холбогдох мэдээллийг өгсөн байна.


8.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдал




Тус байгууллагаар үйлчлүүлсэн иргэдээс “Таны үйлчлүүлсэн байгууллагын албан хаагчийн нэр, албан тушаал, хаягжилт гэх мэт мэдээлэл нээлттэй байсан уу?” гэж асуухад 56% нь “Зарим мэдээлэл байсан”, 36% нь “Тийм бүх мэдээлэл байсан”, үлдсэн 8% нь “анзаараагүй” гэж хариулжээ.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас иргэд олон нийтэд зориулсан үйл ажиллагааг хэр зохион байгуулж байгааг 1-5 оноогоор үнэлүүлэхэд иргэд 2.1 оноо, Төрийн албан хаагч, хуульчид 2.3 оноо буюу дунджаас доогуур үнэлсэн байна.

Нөгөө талаас иргэдийн идэвх оролцоог судалгаанд оролцсон иргэд, Төрийн албан хаагч хуульч, 10 гаруй хувь хангалтгүй, 50 хувь нь хангалттай гэж үнэлж байна.




Иргэд
үнэлгээ

- **Мэдээллийн эх сурвалж**



Тус байгууллагын үйлчилгээний талаарх мэдээллийг телевиз болон цахим сувгаар авахаас гадна гар утасны апп хөгжүүлэх, ebarimt апп дээрээс авах, цахим үнэмлэхний бар кодыг ашиглан хүссэн мэдээлэл лавлагаагаа авдаг болох нь зүйтэй.

8.5. Хууль, дүрэм, журмын тэгш хэрэгжилтийн үнэлгээ



Мэдээллийн ил тод байдлыг 1-5 оноогоор үнэлүүлэхэд 2.6 оноо буюу дундаас бага зэрэг доош үнэлсэн, үйлчилгээний шуурхай байдлыг иргэд 2.8, төрийн алба хаагч, хуульчид 3 оноогоор үнэлэв.

8.6. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажлуудаас дурдвал:

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2022 оны төлөвлөгөө 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр батлагдаж ирсэн бөгөөд уг төлөвлөгөөтэй уялдуулан ШШГЕГ-ын алба, газар, хэлтсээс дотоод албан бичгээр санал авч 2022 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр ШШГЕГ-ын 2022 оны “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”-г 5 бүлэг 37 заалттайгаар боловсруулан батлуулж ажилласан байна.

2022 оны 3 дугаар улирлын байдлаар хорих 405 дугаар хаалттай хорих ангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн үйл ажиллагааг шалган зааварчилж, ажиллан дараахь арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн болон зөрчлийн мэдээллийн сангаас дээрх ангийн албан хаагчдын мэдээллийг гаргуулан авахад 2021, 2022 оны эхний хагас жилд гэмт хэргийн санд 3 албан хаагч бүртгэлтэйгээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 270 дугаар зүйлийн 270.3 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь хэсэгт зааснаар шийдвэрлэхээр ажиллаж байна.

Зөрчлийн мэдээллийн санд 30 албан хаагчийн 32 удаагийн зөрчил бүртгэлтэй байв. Албан хаагчийн гаргасан зөрчлийн ихэнхи хувийг замын хөдөлгөөний дүрэм удаа, дараа зөрчиж Зөрчлийн тухай хуулиар торгуулсан зөрчил эзэлж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс олгосон тестээр тус ангийн 67 албан хаагчийг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх шинжилгээнд хамруулахад ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

2022 оны 3 дугаар сард 405 дугаар хаалттай ангид хийсэн шалгалтын нөхцөл


байдлыг нийт албан хаагчдад танилцуулж,⁸⁰ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс албан хаагчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг хангалтгүй зохион байгуулсан гэж дүгнэж, цаашид анхаарч ажиллах талаар ХШАБГ-ын дарга, хурандаа М.Алтан- Очир биечлэн үүрэг чиглэл өгч ажилласан байна.

2022 оны 3 дугаар улирлын байдлаар баривчлагдсан төрийн албан хаагчийн мэдээллийн санд нийт 41 албан хаагч бүртгэлтэйгээс ШШГБ-аас 1 /427 дугаар хаалттай хорих анги/ албан хаагч бүртгэлтэй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар “Миний ухаарал” сэдэвт илтгэлийн уралдааныг Хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас тус ангид 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, арга хэмжээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Аюулгүй байдал тусгай ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Ж.Энхтайван, тус ангийн дарга, хурандаа Ц.Хишигбаяр, ХЗДХЯ-ны ахлах мэргэжилтэн Б.Одмандах, Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Т.Жаргалсайхан, БЗД-ийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Ч.Мэндсайхан нарын албаны хүмүүс оролцсон байна.

Миний ухаарал сэдэвт илтгэлийн уралдаанд 20 гаруй хоригдол бүтээлээ ирүүлснээс 2 дугаар шатанд найман илтгэл шалгарч, илтгэлийн уралдаанд оролцсон хоригдлуудаас 1, 2, 3 байрыг эзлүүлэн өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ



8.7. Цахим хуудасны хүртээмжтэй байдал

Цахим хуудасны хүртээмжтэй байдлыг: -хэрэглэгч харилцаж болох байдал, цахим хуудасд байх мэдээллийн хүртээмжтэй байдлын үзүүлэлтээр хэмжиж үнэлсэн болно. Цахим хуудсанд “нэвтрэх”, “бүртгүүлэх” гэсэн цонх байгаа нь хэрэглэгч чөлөөтэй харилцаж болох боломжийг бүрдүүлжээ. Өргөдөл, гомдол цахимаар гаргах боломж нь “нэвтрэх” “бүртгүүлэх” цонхоор дамжин нээлттэй байгаа ч өргөдөлийг авсан эсэх, хаана ямар шатанд явааг хянах

боломжгүй байна. Цахим хэрэглээний хүртээмжийн хувьд үндсэн цэсний мэдээлэл шинэчлэгдэхгүй байгаа нь хэрэгцээтэй мэдээлэл авах боломжийг хязгаарлаж байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагааны ил тод байдлыг байгууллагын тухайн оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний биелэлт, хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн мэдээллээр баяжуулж тэдгээрийг ил тод байлгах шаардлагатай юм. Иргэд харилцагч байгууллагууд хөндлөнгийн хяналт тавих боломжийг байгууллагын цахим хуудас хангахгүй байгааг өөрчлөх шаардлагатай байна. Дээрх хуулийн 7.1.2-т “үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/- ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх” –ээр заасан байгаа. Энэ ажлыг хариуцсан хүнтэй байх шаардлага ч байна. Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад мэдээллийг тухайн байгууллагаас авах эрхтэй байдаг. Энэхүү иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаснаар төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг хэмжих шаардлага ч зүй ёсоор тавигдаж байна.

Цахим хуудасны хэрэглэхэд хялбар байдлыг: - өнгө, - хэлбэр загвар, - хэрэгцээтэй мэдээлэл олж авч болох эсэх гэсэн хэмжээсээр үнэлсэн болно. Хайлтын систем нь хэвийн ажиллаж байгаа бөгөөд цахим хуудасны өнгө, хэлбэр загвар нь хангалттай сайн байна.

Цаашид байгууллагын цахим хуудсанд байгаа мэдээллийг цаг тухайд шинэчилж, тусгайлан зохицуулсанаас бусад мэдээллийг ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах нь зүйтэй байна.

Байгууллагын цахим хуудсыг иргэд мэдээлэл авах үндсэн эх үүсвэр хэмээн үзэж, хөгжүүлэлт, сайжруулалт хийх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2022 оны “Хэрэглэгчийн үнэлгээ”-г Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилтийн байдал болон харьяа байгууллагуудын зүгээс иргэд олон нийтэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмж, шуурхай байдал болон дээрх асуудлуудын талаарх иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг 389 иргэдээс 70 орчим асуулт бүхий анкетын санал асуулга авч,иргэд, хуульч,удирдах ажилтан экспертүүдтэй ярилцлага хийх замаар чанарын судалгаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын цахим хуудаг ажиллалтын судалгааг хийж гүйцэтгэв.

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хуульчдын зүгээс өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ иргэдээс өндөр байгаа нь салбарын мэдээлэлд илүү ойр байдагтай холбоотой юм.

Санал асуулгын судалгаанд сонгогдсон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харъяа байгууллагуудыг иргэдийн өгсөн үнэлгээгээр жагсаавал Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Баривчлах төв, 409, 421, 455 дугаар ангиуд байна. Харьяа байгууллагын албан хаагчид өөрсдийн ажиллаж буй байгууллагаа хэрхэн үнэлснийг харьцуулан харвал, алба хаагчид өөрсдийн байгууллагаа хамгийн өндрөөр үнэлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар 2020,2021 онд үйлчлүүлсэн иргэдийн 37 хувь нь хүссэн үйлчилгээгээ бүрэн авч чадсан гэж хариулсан бол 2022 оны судалгаагаар 52 хувь болж өссөн байна. Үйлчилгээ авсан иргэдийн 30 хувь нь нэг удаагийн хандалтаар, 39 хувь нь хоёр удаагийн хандалтаар, 26 хувь нь 3-4 удаагийн хандалтаар, 5 хувь нь 5-аас дээш удаагийн хандалтаар хүссэн үйлчилгээгээ авч дуусгасан байна.

Үйлчилгээний чанар хүртээмжийг NPPScore оноо иргэдийнх (-39%), төрийн албан хаагч, хуульчид (-46%) гарсан. Энэ нь үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой хийж байгаа ажил, гаргаж байгаа шийдвэрт шүүмжлэлтэй хандаж байгааг илэрхийлж байгаа бөгөөд гарсан алдаа дутагдалд иргэдийн 39 хувь харьяа агентлаг, байгууллагын албан хаагч, хуульчдын 46 хувь нь илүүтэй ач холбогдол өгч байна.

Эдгээрийг 3 бүлэг зорилтод багцлан тус бүрээр дүгнэж үзвэл:

- **Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон түүний харьяа байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамж, иргэдийн оролцоо, шударга ёсны талаарх үнэлгээ**

Энэ хэсгийг бүхэлд нь дүгнэж үзвэл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын болон харьяа байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамж, иргэдийн оролцоо, шударга ёсны талаарх үнэлгээ “хангалттай” хэмжээнд буюу **70%-иас 65.7%**-ийн үнэлгээтэй гарч байна.

- **Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, төрийн албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйн талаарх үнэлгээ**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний орчин, нөхцөлийн нийлбэр дүн хамгийн өндөр буюу 3.9 гарсан. Төрийн байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмж, харилцаа, ёс зүй, орчин нөхцөлийг үнэлүүлэхээр 18 асуулт асуухад ганцхан “Байгууллагын гадна болон доторх таних, тэмдэг, тэмдэглэгээ, харагдахуйц ойлгомжтой байдал”-д иргэд сэтгэл ханамжтай байдал дунджаас дээгүүр гарсан нь **30%- ийн онооноос 24.8%** -ийн үнэлгээ авч байна.

- **Байгууллагын мэдээлэл авдаг, авахыг хүсч буй сувгуудын сэтгэл ханамжийн**

Төрийн мэдээллийг судалгаанд хамрагдсан иргэдийн 47% нь цахим хаягнуудаас, 35% нь телевизээс авсан байна. Иргэд төрийн байгууллагын мэдээллийг цахим орчин, цахим хуудас болон телевизийн сувгаар хүлээн авч байгаа бөгөөд энэхүү хоёр сувгаар төрийн байгууллагын мэдээллийг авах хүсэлтэй байна. Иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг мэдээлэл авах нэг суваг гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Эдгээрээс дүгнэж үзвэл салбарын нийт үйл ажиллагаа болон үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ $65.7\% + 24.8\% = 90,5\%$ болж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, алба хаагчдын харилцааны соёл, ёс зүйн талаарх үнэлгээг хийлээ, Үнэлгээний нэгдсэн дүнгээр **90,5% буюу 4,5 гэсэн оноотой байна.**

Нийт үнэлгээ 90,5% байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тавьсан зорилтдоо хүрч, төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа гэсэн үзүүлэлтээр дүгнэгдэж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон түүний харьяа байгууллагын үйл ажиллагаанд өгсөн ерөнхий сэтгэл ханамж, иргэдийн оролцоо, шударга ёсны талаарх үнэлгээ, байгууллагын мэдээлэл авдаг, авахыг хүсч буй сувгуудын сэтгэл ханамжийн байдал, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцөл, төрийн албан хаагчийн харилцааны соёл, ёс зүйн талаарх үнэлгээ, иргэд болон төрийн алба хаагч, хуульчдаас авсан судалгаагаар өндөр үнэлэгдсэн байгааг тогтмолжуулан цаашид илүү үр бүтээл гарган ажиллах нь зүйтэй. Судалгааны асуултаар төдийлэн гарч ирэхгүй зарим асуудлыг цаашид үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллах талаар зарим асуудлыг зөвлөж байна. Жишээ нь томоохон бодлогын баримт туссан арга хэмжээг эрчимжүүлэх Үүнд:
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн актуудын хэрэгжилт, үр нөлөөнд дүн шинжилгээ хийх ажлыг эрчимжүүлэх.; //АХ 2050-ийн 7.4.1/
 - Хорих анги болон алба хаагчийн аюулгүй байдлыг хангах дохиоллын системийг судлан нэвтрүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх.; /АХ 2050-ийн 7.4.27, ҮЧ-ийн 7.4.1, ЗГҮАХ
 - Стандарт шаардлагад нийцсэн албадан эмчлэх эмнэлгийн байрны асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх; /ЗГҮАХ-ийн 4.3.4/ Эдгээр арга хэмжээ нь Алсын хараа-2050, Үндсэн чиглэл, Засгийн үйл ажиллагааны хөтөлбөрт зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан байх тул нарийвчлөн төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй байна.
 - Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэн, ажлаас гарч байгаа шалтгааныг судлан үзэх;
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд ажлын байрны хөндлөнгийн судалгаа хийлгэж ажлын ачаалалыг зөв тогтоох;
- Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа ангиудаар судалгаа хийх явцад байгууллагын удирдлагууд болон алба хаагчдын ярилцлагаас хүний нөөцийн хэрэгцээ дутмаг,

алба хаагчид ажлаас гарч байгаа, алба хаагчдын цалин урамшуулал бага байгаа талаар нилээдгүй санал хэлж байгааг судлан шийдвэрлэх;

- Мөн Нээлттэй дэглэмд ял эдэлж байгаа оношийн хүндрэл өгч болзошгүй анхаарал татсан өвчтэй, архаг хууч өвчтэй хоригдолууд багагүй байна. Эдгээр хоригдлуудын эрүүл мэндэд үзүүлэх эмчилгээний төсөв, зардал хүрэлцдэггүй, түүнчлэн өвчний хүндрэл нас баралт гарах өндөр эрсдэлтэй байгааг анхааран үзэх нь зүйтэй.

СУДАЛГААНЫ БАГ

2022.12.06